ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2023

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР 3

ХУРААНГУЙ ТАЙЛАН 4-6

Бүлэг 1 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ 7-13

Бүлэг 2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ 14-19

Бүлэг 3 ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ 20-27

Бүлэг 4 НИЙЦЛИЙН АУДИТ 28-35

Бүлэг 5 БУСАД АУДИТ, АРГА ХЭМЖЭЭ, ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ 36- 37

Бүлэг 6 ДОТООД АЖИЛ 38-48

Бүлэг 7 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ 49-51

Бүлэг 8 ДҮГНЭЛТ, САНАЛ 52

Хавсралт

1. Байгууллагын 2022 оны аудитын дүгнэлт 53-54

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АШ	Албан шаардлага
ГА	Гүйцэтгэлийн аудит
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
НА	Нийцлийн аудит
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТАХ	Төсөл, арга хэмжээ
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭЭС	Эмийн эргэлтийн сан

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ ТАЙЛАН

Дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/05 дугаар тушаалаар Төрийн аудитын байгууллагын 2023 оны зорилтыг **"Аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах"** жил болгон зарласан.

Зорилтыг хэрэгжүүлэх дэд төлөвлөгөөг дарга, тэргүүлэх аудиторын А/08 дугаар тушаалаар баталж, хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Төлөвлөгөөний дагуу аудитын шийдвэрийн хэрэгжилт, үр нөлөөг тооцоход тулгарч буй хүндрэлтэй асуудлыг тодорхойлох хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлгийн үр дүнд тодорхойлсон хүндрэлтэй асуудал, түүнийг шийдвэрлэх 5 саналыг ажлын хэсэгт хүргүүлж ажиллав.

"Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн" /2021/, "Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө" /2021/, "Усны чанар, аюулгүй байдал, хүрэлцээ, хангамжийн талаар баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн" /2022/, "Цөлжилт, газрын доройтлын эсрэг хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний хэрэгжилт, үр дүн" /2022/, "Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн" /2022/, “Төрөөс бүх нийтийн боловсрол олгож буй өнөөгийн байдал үр дүн” /2020/-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлагналын дараах үе шатны ажлыг хэрэгжүүлж, уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, олон нийтэд тайлагнах ажлыг төлөвлөсөн нь 2023 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх онцлог ажлын нэг юм.

2020- 2022 онд гүйцэтгэсэн давтан аудитын үр дүнд зөвлөмж бүрэн хэрэгжүүлээгүй, хэрэгжилт хангалтгүй 4 асуудалд зөрчил арилгах хугацаатай албан шаардлага хүргүүллээ.

Удирдлага зохион байгуулалт

Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт 26, нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт 12, үйл ажиллагааны чанар, хүртээмжийг сайжруулах зорилт 10, нийт 48 зорилт, арга хэмжээг тусган, МУЕА-аар баталгаажуулан, хэрэгжилтийг улирал бүр тайлагнаж байна.



Төрийн аудитын газар нь бүтэц зохион байгуулалтын хувьд аудитын 3 нэгж, дэмжих үйлчилгээний нэгжийн хүрээнд нийт 12 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна. Нийт ажилтны 60 хувь нь эрэгтэй, 40 хувь нь эмэгтэй, дундаж нас 42, ажилтны 60 хувь нь төрийн аудитын байгууллагад 10-аас дээш жил ажилласан байна.

Ажилтнууд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, улирал бүр үйл ажиллагааны үр дүнгээ тайлагнаж байна. Харин нярав-жолоочтой хөдөлмөрийн гэрээ байгуулан, нягтлан бодогч, дотоод ажил, архив, бичиг хэрэг, мэдээллийн технологийн ажлуудыг аудиторуудад хавсруулан гүйцэтгүүлж байна.

Аудитын үр дүн

Төрийн аудитын газар 2023 онд **210** төсөв захирагчийн санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит, нэгдсэн удирдамжаар **3** гүйцэтгэлийн аудит, өөрийн санаачилгаар **1** гүйцэтгэлийн аудит, нөхөн сонгуультай холбоотой **4** нийцлийн аудит, Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын нэгдсэн удирдамжаар **1** нийцлийн аудит, Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд дүгнэлт гаргах аудитыг тус тус хийхээр төлөвлөсөн.

Тайлант хугацаанд аудитын үр дүнгээс 2,067.7 сая төгрөгийн үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсэн бөгөөд нэг төгрөгт ногдох үр өгөөж **4.3** төгрөг байна.

Санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 7,820.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 3,862.2 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 2,587.8 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлж, хохирлыг нөхөн төлүүлэхээр 211.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахаар 1,158.9 сая төгрөгийн зөвлөмжийг тус тус хүргүүллээ.

Санхүүгийн тайлангийн аудитад **210** байгууллага хамрагдаж, бүх шатны төсөв захирагч нарын 2022 оны санхүүгийн тайлангаа холбогдох хууль тогтоомж, стандарт, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын шаардлагад нийцүүлэн үнэн зөв, шударгаар тайлагнасан эсэхэд аудит хийж баталгаажууллаа. Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т заасны дагуу санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгүүлэхээр Азуре хүлүг аудит, Си Пи Ти Эй аудит ХХК-тай гэрээ байгуулж, 58 байгууллагыг хуваарилан гүйцэтгүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,609.3 сая төгрөгийн үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэв.

Гүйцэтгэлийн аудит

2023 онд нэгдсэн удирдамжаар гүйцэтгэх "*Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг*", "*Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө*", "Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж" сэдэвт **3** гүйцэтгэлийн аудит, өөрийн санаачилгаар "*Хог хаягдлын менежментийг сайжруулах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн*" сэдвээр **1** гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасныг бүрэн хэрэгжүүлээд байна.

Гүйцэтгэлийн аудитаар нийт **693.7** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулах **446.1** сая төгрөгийн хугацаатай албан шаардлага, үр ашгийг нэмэгдүүлэх 35 заалт бүхий **247.6** сая төгрөгийн зөвлөмжийг шалгагдагч байгууллагад хүргүүллээ.

Гүйцэтгэлийн аудитыг хэрэгжүүлэхдээ тухайн сэдэвтэй холбоотой дүн шинжилгээ хийх аргыг ашиглан, эдийн засгийн харьцуулсан тооцооллыг хийж, түүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан.

Гүйцэтгэлийн аудитаар нийт **458.4** сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэв.

Нийцлийн аудит

2023 онд Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэх “*Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт”* **1** нийцлийн аудит, хуулийн дагуу гүйцэтгэх “*Адаацаг, Баянжаргалан, Өлзийт, Хулд сумдын нөхөн сонгууль зохион байгуулах”*-тай холбоотой мөрийн хөтөлбөр, хандивын тайланд дүгнэлт гаргах, сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд аудит хийх, сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланд аудит хийх **4** нийцлийн аудитыг дуусгахаар гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасныг бүрэн хэрэгжүүлээд байна.

Орон нутгийн 2024 төсвийн төсөлд дүгнэлт гаргах аудитын гүйцэтгэлийн үе шатны ажлыг дуусган, тайлагналын үе шатанд ажиллаж байна.

Нийцлийн аудитаар **106.6** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулах **106.6** сая төгрөгийн хугацаатай албан шаардлага, үр ашгийг нэмэгдүүлэх 9 заалт бүхий зөвлөмжийг шалгагдагч байгууллагад хүргүүллээ.

Сургалтын үйл ажиллагаа

Төрийн аудитын байгууллагын 2023 оны зорилт, Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр ажилтнуудын сургалтын хэрэгцээнд тулгуурлан “Сургалт, хөгжлийн төлөвлөгөө”-г баталлаа. Байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөнд ажилтнуудын ур чадварыг сайжруулах, аудитын ажлыг сайжруулахад чиглэсэн сургалтын сэдвүүдийг хамруулан боловсруулсан. Дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу 11 удаагийн сургалт зохион байгуулав. Үүнд:

- "*2023 онд гүйцэтгэх санхүүгийн аудитад бариимтлах чиглэл арга зүй”*
- “*Санхүүгийн тайлангийн аудитад анхаарах асуудлууд*”
- “*Аудитын чанарын хяналтын журам*”
- *"Төрийн сангийн удирдлагын цахим систем"*
- *"Аудитын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний үр дүн"*
- *"Алсын хараа-2050 Монгол Улсын хөгжлийн бодлого"*
- *"Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга"*
- *" Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга"*
- *“Байгууллагын соёл, түүний ойлголт"*
- *"Эксел программ дээр ажил хөнгөвчлөх үйлдэл, томьёо"*
- *“Инфографикийг хэрхэн бэлтгэх”*

2023 онд Үндэсний аудитын газраас зохион байгуулсан цахим болон танхимын хосолсон 10 сургалтад 12 ажилтан, Excel, Dashboard, Power Bi, Дата анализ болон Data science-ийн системтэй мэдлэг, ур чадварыг олгох Data School (https://data-school.mn/)-ийн 3 багц сургалтад цахимаар 10 ажилтан оролцов.

Санхүүгийн үйл ажиллагаа

2023 оны 12 дугаар сарын байдлаар 572.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас санхүүжилтийг бүрэн авч, эдийн засгийн ангиллын дагуу 483.9 сая төгрөгийг зарцуулан 88.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ. Нийт 9.3 сая төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авч тохижуулалт хийсэн байна.

1 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.1 Төрийн аудитын байгууллагын стратеги, 2023 онд дэвшүүлсэн зорилт

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/76-1 дугаар тушаалаар Төрийн аудитын байгууллагын 2019-2024 онд хэрэгжүүлэх “Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг хараат бусаар явуулах эрхзүйн болоод аргазүй технологийн таатай орчныг бүрдүүлнэ.” гэсэн стратеги зорилгын хүрээнд 6 зорилт дэвшүүлсэн бодлогын баримт бичгийг баталсан.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/05 дугаар тушаалаар Төрийн аудитын байгууллагын 2023 оны зорилтыг **"Аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах"** жил болгон зарласан.

Зорилтыг хэрэгжүүлэх дэд төлөвлөгөөг дарга, тэргүүлэх аудиторын А/08 дугаар тушаалаар баталж, хэрэгжилтийг тооцон ажиллав. 2020-2022 онд хийсэн 5 гүйцэтгэлийн аудитын тайлагналын дараах үе шатны ажлыг хэрэгжүүлж, уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, олон нийтэд тайлагнах ажлыг төлөвлөсөн нь 2023 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх онцлог ажлын нэг юм. Тус аудитуудын тайлагналын дараах үе шатны ажлыг хэрэгжүүлж давтан аудитыг гүйцэтгэхэд аудитаар өгсөн зөвлөмжийн хүрээнд дараах ажлуудыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байлаа. Үүнд:

"***Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн***" хийсэн аудитын хүрээнд аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 24 –ний өдрийн А/411 тоот захирамжаар 12 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” хөтөлбөрийн хүрээнд хийгдэх 5 жилийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг тооцон ажиллаж байгаа нь аудитаар өгсөн зөвлөмж үр дүнтэй хэрэгжсэн сайн жишээ байлаа.

“***Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө***”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн 3 зөвлөмж, дээд шатны байгууллагад хүргүүлсэн 3 саналын хэрэгжилтийг шалгасан. Шалгалтаар ажил хариуцсан аймгийн Нийгмийн бодлогын эм, эмнэлгийн хариуцсан мэргэжилтэн, Эрүүл мэндийн газрын дарга, холбогдох мэргэжилтэн, аймгийн ИТХ-ын мэргэжилтэн нартай уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, албан шаардлагын хэрэгжилтийг эмийн сангуудаар явж шалгасан. Шалгалтаар хэрэгжилт хангалтгүй 3 асуудал дээр ажлыг сайжруулах хэрэгжилтийг хангаж ажиллах хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

"***Усны чанар, аюулгүй байдал, хүрэлцээ, хангамжийн талаар баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн"***-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хүрээнд дараах ажлуудыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна. Үүнд:

❖ Азийн хөгжлийн банкны 250 сая төгрөгийн санхүүжилтээр аймгийн хлоржуулалтын станцын усны нөөцийн байгууламжид ус зөөлрүүлэх төхөөрөмж /эрдэс бодис, давс, нүүрс г.м 20 тн бүтээгдэхүүн /нийлүүлэгдсэн байна. Аймгийн ОНХС-гаас тухайн станцын байгууламжийг шинээр барих ажилд 210.0 сая төгрөг батлаж худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаад байна. Байгууламж баригдсан даруйд тоног төхөөрмжийг нийлүүлэгч байгууллагаас технологийг хариуцаж, ашиглалтад хүлээлгэн өгөх төлөвлөгөөтэй байна.

❖ Дундговь-Ус ОНӨҮГ-т 2 өрөөг засварлан тохижуулах, лабороторийн тавилга эд хогшил авахад 8.1 сая төгрөгийг зарцуулсан байна. Лабороторийн ажилтны батлагдсан орон тоонд 1 ажилтныг авч орон нутагт дадлагажуулж байна. Лароторийн үйл ажиллагааг эхлүүлэх тусгай зөвшөөрөл авах зорилгоор холбогдох газруудад албан тоотыг хүргүүлсэн байна. Лабороторид шаардлагатай тоног төхөөрөмжүүд 2014-2020 онд бүрэн нийлүүлэгдсэн ашиглахад бэлтгэж байршуулсан байна.

"***Төлжилт, газрын доройтлын эсрэг хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний хэрэгжилт, үр дүн***"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хүрээнд үр дүнтэй хэрэгжүүлсэн дараах ажлыг онцолж байна. Үүнд:

❖ Хөрсний доройтлын судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж, газар зүйн байршлыг нарийвчлан тогтоож, судалгааг үндэслэн маш хүчтэй доройтсон төлөв байдалд буй Дэлгэрцогт, Дэрэн, Адаацаг сумдын 85060.21 га талбайд заавар зөвлөмжийн дагуу арга хэмжээг хугацаа алдалгүй хэрэгжүүлэх, сэргэх чадавхын 4 дүгээр түвшинд байгаа 15 сумдын 85 цэгийн 1696381.02 га талбайд

арга хэмжээ авч сэргэх чадавхын ангиллыг сайжруулах ажлуудыг гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна.

- Бэлчээрийн доройтлыг газар нутгаар нарийвчлан гаргаж, бэлчээрийг нөхөн сэргээх, хамгаалах ажлыг эхлүүлснээр цаашид хөрсний доройтолд орсон газрын хэмжээ бууруулах ажлын эхлэл тавигдаж байна.

"***Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн"***-д хийсэн аудитын үр дүнг давтан шалгахад дараах үр дүн гарсан байна. Үүнд:

- Төслийг сонгон шалгаруулахдаа төслийн үндэслэл, хэрэгцээ шаардлага, зах зээлийн багтаамж, эдийн засгийн тооцоолол, санхүүжилтийн зарцуулалт, хүрэх үр дүн, ажил хөдөлмөр эрхэлдэг эсэх, зээлийн мэдээлэл, аж ахуй эрхлэлтийн сургалтад хамрагдсан эсэхэд үндэслэн иргэн өөрөө төслөө хамгаалдаг нь зээлийн эргэн төлөлт хэвийн болж, төсөл хөтөлбөр бүрэн хэрэгжих боломжтой үр дүнтэй ажил болсон байна.
- И-жоб программ 2023 оны 1 дүгээр сараас ашиглалтад орж профайлингийн үнэлгээ хийснээр ажилгүй иргэдийн тоон мэдээлэлд тулгуурлан ажилд зуучлах, төсөл хөтөлбөрт хамрагдах иргэдэд дүгнэлт хийх, сургалтад хамруулах үйлчилгээ сайжирч үүний үр дүнд 667 иргэнийг ажилд зуучилсан байна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дансанд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөрийг бүрэн төвлөрүүлээгүй зөрчилд хүргүүлсэн албан шаардлагын хүрээнд 68.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн.
- Аудитаар өгсөн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлд тавигдсан төлбөрийн актын авлагыг барагдуулах зорилгоор ажлын хэсгийн байгуулан ажилласнаар 153.5 сая төгрөгийн үлдэгдэл авлагаас 81.7 сая төгрөг буюу 53.3 хувийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлсэн.

1.2 Бүтэц, зохион байгуулалт

Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт 26, нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт 12, үйл ажиллагааны чанар, хүртээмжийг сайжруулах зорилт 10, нийт 48 зорилт, арга хэмжээг тусган, МУЕА-аар баталгаажуулан, хэрэгжилтийг улирал бүр тайлагнаж байна.

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар нь 12 орон тоогоор үйл ажиллагаа явуулахаар батлагдсан. Дарга, тэргүүлэх аудитор аудит хариуцсан нэгж болон дэмжих үйлчилгээний нэгжийг хариуцан, аудитын менежер аудитын 3 нэгжийн үйл ажиллагааг хянан удирдахаар зохион байгуулсан. Аудитын 1-р нэгжид 4, Аудитын 2-р нэгжид 3, Аудитын 3-р нэгжид 2 хүний бүрэлдэхүүнтэй, дэмжих үйлчилгээний нэгжид нягтлан бодогч, нярав жолооч ажиллаж, нийт 12 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.



Нийт ажилтны 60 хувь нь эрэгтэй, 40 хувь нь эмэгтэй, дундаж нас 42, ажилтны 60 хувь нь төрийн аудитын байгууллагад 10-аас дээш жил ажилласан байна.

Ажилтнууд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, улирал бүр үйл ажиллагааны үр дүнгээ тайлагнадаг. Харин нярав-жолоочтой хөдөлмөрийн гэрээ байгуулан, нягтлан бодогч, дотоод ажил, архив, бичиг хэрэг, мэдээллийн технологийн ажлуудыг аудиторуудад хавсруулан гүйцэтгүүлж байна.

Төрийн аудитын газрын ажилтнуудын 10 нь нягтлан бодогч, эдийн засагч мэргэжилтэй, бүгд Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхтэй.

1.3 Аудитын статистик үзүүлэлт



Төрийн аудитын газар 2023 онд **210** төсөв захирагчийн санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит, нэгдсэн удирдамжаар **3** гүйцэтгэлийн аудит, өөрийн санаачилгаар **1** гүйцэтгэлийн аудит, бодлогоор хэрэгжүүлэх **1** нийцлийн аудит, нөхөн сонгуультай холбоотой **4** нийцлийн аудит хийхээр төлөвлөсөн.

Санхүүгийн тайлангийн аудитад **210** байгууллага хамрагдаж, бүх шатны төсөв захирагч нарын 2022 оны санхүүгийн тайлангаа холбогдох хууль тогтоомж, стандарт, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын шаардлагад нийцүүлэн үнэн зөв, шударгаар тайлагнасан эсэхэд аудит хийж баталгаажуулаа.

2023 онд нэгдсэн удирдамжаар гүйцэтгэх "*Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг*", "*Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө*", "Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж" сэдэвт **3** гүйцэтгэлийн аудит, өөрийн санаачилгаар "*Хог хаягдлын менежментийг сайжруулах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн*" сэдвээр **1** гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэлээ. Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэх "*Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт*" **1** нийцлийн аудит, хуулийн дагуу гүйцэтгэх "*Адаацаг, Баянжаргалан, Өлзийт, Хулд сумдын нөхөн сонгууль зохион байгуулах*"-тай холбоотой мөрийн хөтөлбөр, хандивын тайланд дүгнэлт гаргах, сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд аудит хийх, сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланд аудит хийх **4** нийцлийн аудитыг дуусгахаар гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасныг бүрэн хэрэгжүүлээд байна.

Гүйцэтгэл, нийцэл, санхүүгийн тайлангийн аудитаар нийт **8,620.9** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 22 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Тайлант хугацаанд хохирлыг нөхөн төлүүлэх **211.7** сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах **3,140.5** сая төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, **1,406.5** сая төгрөгийн 165 заалт бүхий зөвлөмжийг шалгагдагч байгууллагад хүргүүлжээ. Аудитын явцад **3,862.2** сая төгрөгийн алдааг залруулсан байна.

Аудитаар тогтоосон төлбөрийн актын дүнг сүүлийн 6 жилээр харьцуулахад 2023 онд өмнөх оноос 76.3 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй, 2021 оноос 41.7 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Төлбөрийн актын 2023 оны нийт үлдэгдэл 341.3 сая төгрөг, үүнээс хугацаа болоогүй 1.7 сая төгрөг, хугацаа хэтэрсэн үлдэгдэл 339.6 сая төгрөг байна.

Энэ нь төлбөрийн акттай холбоотой асуудал шүүхийн байгууллагад шилжин, хэрэгжилт удааширсан байна.



Албан шаардлагын үлдэгдэл 146.0 сая төгрөг, үүнээс хугацаа болоогүй 1.9 сая төгрөг, хугацаа хэтэрсэн 144.1 сая төгрөг байна.

2023 онд албан шаардлагын дүн өмнөх оноос 1.5 дахин буурсан байна.

2023 оны зөвлөмжийн эхний үлдэгдэл 29, тайлант онд 165 заалт бүхий 1,406.5 сая төгрөгийн зөвлөмжийг харилцагч байгууллагад хүргүүлснээс 41 заалт зөвлөмжийн хэрэгжилт ирүүлэх хугацаа болоогүй, 153 заалт зөвлөмж хэрэгжсэнээр хугацаа хэтэрсэн зөвлөмж байхгүй байна.

Аудитын дүнд үйл ажиллагаа, чиг үүргийг сайжруулах чиглэлээр өгсөн зөвлөмжийн тоо өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байгаа нь 2023 онд гүйцэтгэсэн гүйцэтгэл, санхүүгийн тайланийн аудитаар өгсөн зөвлөмжийн өсөлттэй холбоотой байна. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах, аймгийн хэмжээнд тулгамдсан асуудлыг бодлогын түвшинд шийдвэрлэх, төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтийг дүгнэн ажиллах, аудитын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулсан.

Тайлант хугацаанд аудитын үр дүнгээс 2,067.7 сая төгрөгийн үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсэн бөгөөд нэг төгрөгт ногдох үр өгөөж **4.3** төгрөг байна.



2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Санхүүгийн тайлангийн аудит

2. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ҮР ДҮН

2.1 “Төсөв захирагч нарын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит”

Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хуулиар тодорхойлсон чиг үүргийнхээ дагуу улс, орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөл хөтөлбөрийн нийт **210** санхүүгийн тайланд аудит хийхээр төлөвлөснийг бүрэн хэрэгжүүлэн ажиллалаа.

Санхүүгийн тайлангийн аудитад нийт 210 байгууллага хамрагдаж 144 байгууллагын санхүүгийн тайланд санал дүгнэлт өгч, 66 байгууллагын санхүүгийн тайланг хэсэгчилсэн үе шатны ажлыг гүйцэтгэлээ. Санал дүгнэлт өгсөн 144 байгууллагаас 132 байгууллага **“Өөрчлөлтгүй”**, 12 байгууллага **”Хязгаарлалттай”** санал дүгнэлт авсан байна.



Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 7,820.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 3,862.2 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 2,587.8 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлж, хохирлыг нөхөн төлүүлэхээр 211.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахаар 1,158.9 сая төгрөгийн зөвлөмжийг хүргүүллээ.

Тайлант онд аудитаар илэрсэн алдаа, зөрчил өмнөх оны мөн үеэс 2,555.5 сая төгрөг буюу 24.7 хувиар буурсан нь залруулсан алдааны бууралттай холбоотой байна.

2.2 “Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит”

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан, **“Өөрчлөлтгүй”** санал дүгнэлтийг хуулийн хугацаанд аймгийн Засаг даргад гардуулж, аудитын тайланд дурдсан зөвлөмжүүдийг танилцуулав.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 39 төсвийн байгууллага, 17 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, 32 тусгай зориулалтын сан, 15 сумын нэгтгэсэн тайлан, аймгийн Засаг дарга нийт 104 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 63 байгууллагыг аудитад хамруулан, 41 санхүүгийн тайланд дүгнэлт өгсөн байна.



Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 63 байгууллагыг түүвэрт хамруулж, 41 байгууллагад дүгнэлт хүргүүллээ. Үүнд: “Өөрчлөлтгүй” 36, “Хязгаарлалттай” 5 /*Цагаандэлгэр, Хулд Дэрэн, Эрдэнэдалай сумдын нэгтгэсэн санхүүгийн тайлан, Хулд сумын ЗДТГ/* дүгнэлт гаргасан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 5,430.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2,823.2 сая төгрөгийн 111 алдааг аудитын явцад залруулж, 183.4 сая төгрөгийн зөрчилд 70 төлбөрийн акт тогтоож, 1,480.6 сая төгрөгийн зөрчилд 121 албан шаардлага, 943.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд 49 зөвлөмж өглөө.

Аймгийн нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн 48 хувийг залруулагдаагүй, 52 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

2022 оны нэгтгэсэн тайлан тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүнг өмнөх онтой харьцуулахад нийт зөрчил 1,002.6 сая төгрөг, залруулсан алдааны дүн 1,507.4 сая төгрөгөөр буурсан боловч төлбөрийн актын дүн 66.7 сая төгрөг, албан шаардлагын дүн 38.3 сая төгрөг, зөвлөмжийн дүн 399.8 сая төгрөгөөр тус өссөн үзүүлэлттэй байна.



Төсвийн шинэчлэлтэй холбоотойгоор аудитын хамрагдсан төсөвт байгууллагын тоо 77 оор буурсан боловч залруулагдаагүй буюу материаллаг зөрчил нь 504.8 сая төгрөгөөр буюу 24.0 хувиар өссөн байна. Тайланд онд илэрсэн зөрчлийг агуулгаар авч үзэхэд нийт зөрчлийн дийлэнх буюу 23.9 хувийг бараа материалын данс, 17.5 хувийг нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй, 14.2 хувийг мөнгөн хөрөнгийн данстай, 12.7 хувийг хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил эзэлж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас төрд учирсан хохиролтой холбоотой 1, албан тушаалтанд хариуцлага тооцуулах 1, нийт 2 албан шаардлага, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 3 зөвлөмжийг хүргүүллээ.

2.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн гүйцэтгэл

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн гүйцэтгэлд хийх аудитыг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд гүйцэтгэж, аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг даргад тус тус хүргүүллээ.

Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгааг жил бүрээр харьцуулан, мэдээллийн сан бүрдүүлж, дүн шинжилгээ хийсэн нь энэ аудитын онцлог байв.

Татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг 114.4 хувьтай биелүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн орлогыг 40,864.9 сая төгрөгөөр төлөвлөж, 108.5 хувийн гүйцэтгэлтэй, 3,490.8 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн ч Луус, Гурвансайхан, Сайхан-Овоо сумд орлогын төлөвлөгөөг 0.3-2.9 хувиар тасалжээ.

Татварын болон татварын бус орлого 9,533.0 сая төгрөгийг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 10,872.4 сая төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 1,339.4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч татварын орлогыг нэр төрлөөр авч үзэхэд дараах орлогууд тасарчээ.



Иймд тасарсан татварын орлогыг нэр төрлөөр нь биелүүлэхэд анхаарч, тасарсан шалтгааныг тодруулан дүн шинжилгээ хийх талаар аймгийн Татварын хэлтэст зөвлөмж хүргүүлсэн.

Орон нутгийн төсвийн зарлагыг бодитой төлөвлөөгүй, төсвийг хэмнэлтгүй зарцуулсан зөрчлүүд илэрчээ.

Тайлант онд төсвийн нийт зарлага 40,864.9 сая төгрөгийг дараах зардлуудад зарцуулахаар төлөвлөжээ. Үүнд:

Тайлант оны төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад нийт 15,523.0 сая төгрөгөөр бууруулан баталсан байна. Энэ нь улсын төсвийн байгууллагуудын бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

Төсөв захирагчдын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар байгууллага бүрд хамааралтай 29-35 горим сорилыг хэрэгжүүлэн, илэрсэн зөрчлийг шалтгаан, нөхцөл байдалтай уялдуулан, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/89 дүгээр тушаалаар "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх зааврын дагуу шийдлийг гаргаж ажилласан. Аудитаар нийт 288.7 сая төгрөгийн 41 алдаа, зөрчил илэрсэн байна.

Нэмэлт төсвийг эрх нээлгэн зарцуулснаас 70 хувийг бараа, ажил үйлчилгээний зардалд зарцуулжээ.

Нэгтгэсэн тайлангийн нэмэлт санхүүжилтийн зардалд 3,525.2 сая төгрөгийг тайлагнаснаас бараа, ажил үйлчилгээний зардалд 2,468.9 сая төгрөг, татаас, урсгал шилжүүлэгт 296.6 сая төгрөг, хөрөнгийн зардалд 759.7 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хандив, тусламжийн орлого өмнөх оноос 3.9 дахин өссөн нь тус онд аймаг байгуулагдсаны түүх 80 жилийн ой тохиож, ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой зардлыг санхүүжүүлэх зорилгоор иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас өгсөн хандивыг нэмэлт санхүүжилтийн дансанд хүлээн авч, тайлагнасан байна.

Аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар аймгийн Засаг даргад 3 зөвлөмж, аймгийн Татварын хэлтэст 3, Үндэсний аудитын газраар дамжуулан Сангийн яаманд 1 саналыг тус тус хүргүүлэн ажиллалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар 1,609.3 сая төгрөгийн үр өгөөжийг тооцож, хүлээн зөвшөөрүүллээ.

3 ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

ᠬᠤᠪᠢᠳᠠᠯ ᠳᠤᠷᠠᠬᠤᠨ ᠳᠠᠪᠬᠤᠷᠢᠯᠳᠠ

3. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ҮР ДҮН

2023 онд Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар **3** аудит, өөрийн санаачилгаар **1** гүйцэтгэлийн аудит гүйцэтгэхээр төлөвлөснийг хугацаанд нь бүрэн гүйцэтгэж, аудитын тайланг шалгагдагч байгууллага болон Үндэсний аудитын газарт хүргүүллээ.

Гүйцэтгэлийн аудитаар нийт **693.7** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулах **446.1** сая төгрөгийн хугацаатай албан шаардлага, үр ашгийг нэмэгдүүлэх 35 заалт бүхий **247.6** сая төгрөгийн зөвлөмжийг шалгагдагч байгууллагад хүргүүллээ.

3.1 "Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"

Дундговь аймгийн хэмжээнд 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 80,549.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 28 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төсөв батлагдсан байна. Үүнээс 12,076.0 сая төгрөгийн 9 төсөл арга хэмжээ нь эрх шилжин ирсэн, 68,473,3 сая төгрөгийн 19 төсөл арга хэмжээ нь эрх шилжин ирээгүй байна. Эрх шилжин ирсэн төсөл арга хэмжээний хувьд 2022 онд 2,997.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Нийт санхүүжилтийн 2.1 хувийг барилга, байгууламжийн 1, 4.9 хувийг тоног төхөөрөмжийн 2, 47.8 хувийг их засварын 15, 45.2 хувийг ТЭЗҮ боловсруулах 14 төсөл арга хэмжээнд тус тус зарцуулахаар байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор 21 төсөл арга хэмжээнд 1.5 тэрбум төгрөг, 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 27 дугаар тогтоолоор 2022 оны төсөвт өөрчлөлт оруулж орон нутгийн хөрөнгө оруулалтаар 1.9 тэрбум төгрөгийн 32 арга хэмжээг санхүүжүүлэхээр баталжээ.

Нийт санхүүжилтийн 2.1 хувийг барилга, байгууламжийн 1, 4.9 хувийг тоног төхөөрөмжийн 2, 47.8 хувийг их засварын 15, 45.2 хувийг ТЭЗҮ боловсруулах 14 төсөл арга хэмжээнд тус тус зарцуулахаар байна.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн "***Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн зарим төсөл, арга хэмжээ үр дүн багатай байна.***" гэсэн дүгнэлт өгсөн.

"Эрдэнэдалай сумын хатуу хучилттай 2км авто зам", "Говь-Угтаал сумын Спорт залны барилга"-ын гүйцэтгэл удаашралтай, ашиглалтад орсон 199.9 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл, тайланд тусгаагүй зэрэг асуудал илэрчээ.

Аудитаар нийт 446.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 446.0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 4 хугацаатай албан шаардлага, аймгийн Засаг даргад 5, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд 1, ОНӨГ-т 1, нийт 7 заалт бүхий зөвлөмж тус тус хүргүүллээ.

3.2 “ Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө”



Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн **“Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний оношийн бүлэг, эрэмбэлэлт нь бодит байдалтай нийцүүлэн тогтоогоогүйгээс иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хязгаарлагдаж байна.”** гэсэн ерөнхий дүгнэлт өгсөн.

Орон нутагт эрүүл мэндийн байгууллагууд даатгуулагчийн эрэлт,

хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжгүй байна.

Анхан шатны эрүүл мэндийн төвүүдэд үзүүлэх боломжтой тусламж үйлчилгээг лавлагаа шатлалын эрүүл мэндийн төвүүдэд үзүүлэхээр, лавлагаа шатлалаас авах тусламж, үйлчилгээг дараагийн шатлалын тусламж үйлчилгээг авахаар зохицуулж өгсөн нь нэг талаас дээрх байгууллагууд санхүүжилт бүрэн авч чаддаггүй, нөгөө талаас иргэд анхан шатны тусламж үйлчилгээг авч чадахгүй байгаа нь иргэдэд чирэгдэл учруулж байна.

Мөн яаралтай тусламжийн эрэмбийг хязгаарласан, оношийн хамааралтай бүлэгт холбогдолгүй, эмч боловсон хүчний дутагдал, хүн ам цөөтэй хөдөө орон нутаг, алслагдсан байдал зэргээс шалтгаалан Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдлыг бий болгож байна.

Аудитаар нийт аймгийн Засаг даргад 4, Эрүүл мэндийн газарт 2, Нийгмийн даатгалын хэлтэст 1, Эрүүл мэндийн даатгалын хэлтэст 3 нийт 10 заалт бүхий зөвлөмж тус тус хүргүүллээ. Мөн ҮАГ-аар дамжуулан холбогдох яамдад стандарт, дүрэм журам аргачлал боловсруулах, өөрчлөлт оруулах 6 саналыг уламжилсан.

3.3 “Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж”

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгсөн.

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ҮР ӨГӨӨЖ”-Д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: /ДУА-2023/25-10-ШТА-ГА/

Дундговь дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох Утас: 70592439

Аудитын менежер: Х.Наранцацрал Утас: 70592225

Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Батсайхан

Аудитор Б.Гантуяа Утас: 7059-2208,

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлийг дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

Үүнд:

- *Зээлийн хөрөнгийг ашиглагч гэрээнд заасан үүргээ тогтоосон хугацаанд бүрэн биелүүлсэн байна.*
- *Хөдөө аж, ахуйн салбарт эхрэгжүүлсэн тусламж олон нийтийн хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа боловч зарим хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаагүй, үр дүнг тооцож ажиллаагүй байна.*
- *Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.*
- *Төсөл хөтөлбөрийн хүрээнд бий болсон хөрөнгийг тайлангийн хугацаанд тооцоо нийлж бүртгэлийн үнэн зөв байдлыг хангаж, холбогдох байгууллага, хэлтэс агентлагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, хариуцлагатай ажиллах шаардлагатай байна.*

Дундговь аймгийн хөдөө аж ахуйн салбарт 2019-2023 онд нийт 110.0 сая төгрөгийн зээл, 6,421.5 сая төгрөгийн тусламж олгосон байна.

“Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил” төслийн хүрээнд Дундговь аймгийн Адаацаг сумын Бага газрын чулуу жуулчны баазад саалийн ямаа авах, цагаан идээ үйлдвэрлэх зориулалтаар 10.0 сая төгрөгийн, үйл ажиллагаа өргөжүүлж, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн мал нядалгааны үйлдвэр байгуулах зориулалтаар Азтай маамнууд ХХК Төрийн банкнаас эх үүсвэртэй батлан даалттай төслийн 100.0 сая төгрөгийн зээлийг тус тус авч зээлийн эргэн төлөлт хуваарийн дагуу хэвийн төлөгдөж байна.

Дундговь аймгийн хэмжээнд Хөдөө аж ахуйг дэмжих зорилгоор Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Нэгдсэн үндэсний байгууллагын хөдөө аж ахуйн байгууллага, Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил төслийн санхүүжилтээр нийт 6,421.5 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээ хэрэгжсэн байна.

Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүд Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан-3, аймгийг хөгжүүлэх 2020-2025 оны үндсэн чиглэлд тусгагдсан-3 зорилтыг дэмжсэн байна. Төсөл арга хэмжээнүүдийн үр дүнд хөдөө аж ахуйн салбарт хэрэгцээ шаардлагатай хөрөнгүүд бий болсон боловч зарим хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаагүй байна. Тухайлбал: Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил төслийн 119.0 сая төгрөгийн санхүүжилттэй хүнсний ногооны зоорь, Шинэ хөдөө төслийн 49.9 сая төгрөгийн тэжээлийн ургамал тариалах тракторыг зориулалтын дагуу ашиглаагүй байна.

Судалгаагаар аймгийн хэмжээнд ХАА-н салбарт 2019-2023 онд олгосон нийт 6,421.5 сая төгрөгийн тусламжийн ихэнхийг нь “Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил” төсөл 2,975.7 сая төгрөг буюу 46.3 хувийг, Дэлхийн банкны “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төсөл 2,174.4 сая төгрөг буюу 33.8 хувийг тус тус эзэлж байна. Үүнээс “Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил” төслийн тусламжийн хүрээнд Эрдэнэдалай сум 48 буюу 27.3 хувь, Сайхан-Овоо сум 40 буюу 22.7 хувь, Дэлгэрцогт сум 34 ажил хийгдэж 19.3 хувийг тус тус эзэлж байна. Харин мөнгөн дүнгээр авч үзвэл 1,332.2 сая төгрөгийг Сайнцагаан сум авсан нь нийт тусламжийн 44.8 хувь байна.

Тусламжийн арга хэмжээг гүйцэтгэсэн ажлын нэр төрлөөр авч үзвэл “Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил” төслийн 31.4 хувь буюу 934.3 сая төгрөгийг худаг гаргахад, 27.6 хувь буюу 820.9 сая төгрөгийг өвс тэжээлийн агуулах барихад, 12.9 хувь буюу 382.6 сая төгрөгийг борлуулалтын цэг шинээр барихад тус тус зарцуулжээ.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөө, хэрэгжилт болон аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний тайланд аудитад хамрагдсан хугацааны хөдөө аж ахуйн салбарт олгосон зээл тусламжийн хэрэгжилтийн талаар үнэлгээ хийсэн мэдээлэл байхгүй байна.

Төслийн хүрээнд олгогдсон тусламжийн 3,861.6 сая төгрөг буюу 60.1 хувь нь хөрөнгийн чанартай тоног төхөөрөмж, эд зүйл байна. Аудитын явцад тусламжийн хөрөнгийн бүртгэлийг сумдын холбогдох байгууллагын бүртгэлтэй түүвэрлэн тулган шалгалаа. Тулгалтаар “Зах зээл бэлчээрийн удирдлага хөгжил” төслийн тусламжаар хийгдсэн ажил аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ээс ирүүлсэн судалгааны дүн нь холбогдох байгууллагуудын санхүүгийн тайланд бүртгэсэн дүнгээс нийт 22.6 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Тус зөрүү нь судалгаанаас 15.1 сая төгрөгөөр илүү, 7.4 саяар дутуу, тухайлбал Гурвансайхан суманд оготно устгах 5.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж судалгааны дүнд ороогүй, Луус, Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Адаацаг сумдад хийгдсэн худаг, бог малын угаалгын ванн 1.7-4.5 сая төгрөгийн зөрүүтэй байгаатай холбоотой байна.

Аудитаар нийт 230.9 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 62.0 сая төгрөгийн дутуу нийлүүлсэн хөрөнгийн зөрчлийг аудитын явцад залруулж, аймгийн Засаг даргад 3 зөвлөмж хүргүүллээ.

3.4 “Хог хаягдлын менежментийг сайжруулах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн”

“Хог хаягдлын менежментийг сайжруулах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийж аудитын тайлангийн төслийг аудитын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, зөвлөлөөс өгсөн санал, зөвлөмжийг тайланд тусган ажилласан. Аудитаар айл өрхийн хог ачилтын эргэц хоног, нэг айл өрхийн хог хаягдлыг ачиж зайлуулахад гарах зардлыг тооцоолсон. Говийн бүсийн аймгуудын хот тохижуулах газрын хүний нөөц, ажлын ачаалал, машин техникийг харьцуулсан шинжилгээ хийсэн.

Сүхбаатар аймгийн хог ангилан ялгах, дахин боловсруулахтай холбоотой сайн туршлагыг судалж тайланд тусгасан зэрэг нь энэ аудитын онцлог байлаа.

Хог хаягдлын менежментийг сайжруулахтай холбоотой аймгийн бодлогын баримт бичигт 1 зорилтын хүрээнд 2 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Зөвхөн хог ангилан ялгахтай холбоотой зорилт дэвшүүлсэн, зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ нь зорилттой уялдаагүй, зарим шаардлагатай арга хэмжээнүүд орхигдсон байна. Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, судалгаа, дүн шинжилгээ аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгсөн. Бодлогын баримт бичгүүдэд хөтөлбөр, арга хэмжээ бүрийн санхүүжилтийн дүн, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг төлөвлөсөн боловч зорилт, арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх ажил, шаардлагатай төсвийн тооцоолол байхгүй, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг тоон болон чанарын утгаар хэмжигдэхүйц байдлаар бодитой тодорхойлоогүй байна. Ажиллах хүчин, машин механизмын хүрэлцээгүй байдлаас шалтгаалан айл өрхийн хог хаягдлыг тогтмол хугацаанд ачихгүй байна. Аудитын явцад Хот тохижуулах газраас гаргуулан авсан 2022 оны хог хаягдлын ачилт тээвэрлэлтийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж үзэхэд Сайнцагаан сумын хэмжээнд гэр хорооллын 2,749 айл өрхийн хог хаягдлыг давхардсан тоогоор 9,883 удаа ачиж тээвэрлэсэн буюу жилд дунджаар нэг айл өрхийн хог хаягдлыг 3-4 удаа ачиж тээвэрлэдэг буюу эргэц 100.1 хоног байна.

100 Нэг айл өрхийн хог хаягдлыг тээвэрлэх эргэц хоног

ХТГ-ын цалин аймгийн дундаж цалингаас 1.6 дахин доогуур байна

ХТГ-ын нийт албан хаагчдын дундаж цалин 798,000 төгрөг байгаа нь аймгийн хувийн хэвшлийн ААН байгууллагуудын албан хаагчдын дундажтай харьцуулахад 500,000 төгрөгөөр буюу 1.6 дахин доогуур байна.

Аудитаар аймгийн төвийн ачиж тээвэрлэсэн хог хаягдал, хог ачигч, хог тээврийн жолооч, автомашины тоон мэдээллийг бусад аймгуудтай харьцуулж үзэхэд Мандалговь хотын хог хаягдлын тээвэрлэлтэд явж байгаа нэг автомашин буюу жолооч жилд 9,602 тонн хог хаягдлыг тээвэрлэж байгаа бол Даланзадгад хот 2,933 буюу 3.3 дахин, Чойр хот 3,873 буюу 2.5 дахин, Сайншанд хот 3,974 буюу 2.4 дахин бага хог тээвэрлэж байна. Мандалговь хотод нэг хог ачигч жилд 5,401 тонн хог хаягдал ачиж байгаа бол Даланзадгад хот 1,634 буюу 3.3 дахин, Чойр хот 2,767 буюу 2.0 дахин бага байна.

Дундговь аймгийн 15 суманд төвлөрсөн хогийн цэг тус бүр 1 байгаа бөгөөд талбайн нийт хэмжээ 138.3 га байгаагаас 28.7 га талбай нь хашаатай, 109.6 га тайлбай хашаагүй байна. Хашаажуулаагүй нийт талбайн 61.4 га талбайд хур хогтой, түүний 35 га талбай нь зөвхөн Сайнцагаан суманд байгаа бөгөөд хог хаягдлын хэмжээ тогтмол нэмэгддэг байна. Төвлөрсөн хогийн цэгүүдийг хашаажуулаагүй 10 сум, камержуулаагүй 11 сум, сахиул харуулгүй 14 сум, хогийн цэгийг шуух, түрэхэд ашиглах зориулалттай түрэгч механизм (ковш) 9 суманд 10 ширхэг байгаагийн 8 нь хэвийн 2 нь эвдэрсэн ашиглагдахгүй байгаа (Сайнцагаан, Эрдэнэдалай) бол, 6 сум (Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Дэлгэрхангай, Луус, Хулд) ковшгүй байна.

2023 оны 9 сарын байдлаар аймгийн нийт дүнгээр 76.4 сая төгрөг байгаагийн 68.6 сая төгрөг буюу 89.8 хувийг Сайнцагаан сумаас орсон байгаа бол

Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Дэлгэрхангай, Луус, Өлзийт сумд орлого огт төвлөрүүлээгүй байна.

Дулаанаар хангагч байгууллага, барилгын компаниудаас хог хаягдлын хураамжийн төлбөр авахгүй байна. Тухайлбал Сайнцагаан суманд 2021-2023 онд улсын төсвийн хөрөнгө

оруулалтаар 1 цэцэрлэг, 2 сургуулийн барилгыг буулгаж, шинээр барилга барихад барилгын хог хаягдал ихээр гарсан байна. Сайнцагаан сумын 2 дугаар цэцэрлэгээс барилгын хог хаягдлын төлбөр 3.0 сая төгрөг төсөвт төвлөрсөн бол Говийн ирээдүй цогцолбор, Хүмүүнлэг сургуулийн барилгын хог хаягдалд ногдох төлбөр 34.1 сая төгрөг төвлөрөх боломжтой ч төвлөрүүлээгүй байна.

Энгийн хог хаягдлыг цуглуулж тээвэрлэх зардлын нэгж тарифыг сумын ИТХ батлах эрхтэй боловч Говь-Угтаал, Дэлгэрцогт, Луус, Өндөршил, Сайнцагаан сумд баталсан бол үлдсэн 10 сум батлаагүй байна.

Хог хаягдлын тухай хуулийн 8.7.2-д заасан аргачлалаар сумд 1 айл өрхийн хог хаягдлыг ачиж тээвэрлэхэд гарч буй зардлыг огт тооцдоггүй байна. тооцоолол хийхэд ХТГ-аас гэр хороололд одоо байгаа 10 автомашинаар ажлын өдрүүдэд ажлын 8 цагаар тогтмол гарч 1 автомашин өдөрт дунджаар 15 айл өрхийн хог хаягдлыг ачиж тээвэрлэнэ гэвэл хог ачилтын хоногийн эргэц 18.3 хоног болж сард 1 айл өрхийн хог хаягдлыг зайлуулах зардал 22,968.0 төгрөг, төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон өрхийн хувьд одоогийн нормоор ажиллахад хог ачилтын хоногийн эргэц 2.5 буюу сард ногдох зардал 10,939.4 төгрөг байна. Сайнцагаан сум нь сард гэр хорооллын нэг айл өрхөөс 3,000 төгрөгийн хог хаягдлын үйлчилгээний хураамж авч байхад, нэг айл өрхийн хог хаягдлыг зайлуулах зардал 22,968 төгрөг байгаа нь 19,968 төгрөгөөр буюу 7.7 дахин их байна.



Хог хаягдлыг ангилах орчин бүрдээгүй, дахин боловсруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах арга хэмжээ хангалтгүй байна. Аудитын явцад дээрх судалгааны дагуу тооцоолол хийж үзэхэд сүүлийн гурван жилд нийт хог хаягдлын 35 хувь буюу 85,696.6 тн-ыг дахин ашиглах боломжтой байснаас 143.1 тн буюу 0.17 хувийг эдийн засгийн эргэлтэд орж, дахин ашиглах боломжтой 85,553.5 тн хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулахгүйгээр хаясан байна. Сүүлийн 3 жилийн дүнгээр 143.1 тонн дахин боловсруулах боломжтой хог хаягдал цуглуулж, үйлдвэрт тушаасан нь 3 жилийн нийт энгийн хог хаягдлын 0.058 хувь байна.

Гүйцэтгэлийн аудитаар 458.4 сая төгрөгийн үр өгөөжийг тооцож, хүлээн зөвшөөрүүллээ.

4 НИЙЦЛИЙН АУДИТ

4. НИЙЦЛИЙН АУДИТЫН ҮР ДҮН

2023 онд Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэх "*Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт"* **1** нийцлийн аудит, хуулийн дагуу гүйцэтгэх "*Адаацаг, Баянжаргалан, Өлзийт, Хулд сумдын нөхөн сонгууль зохион байгуулах"*-тай холбоотой мөрийн хөтөлбөр, хандивын тайланд дүгнэлт гаргах, сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд аудит хийх, сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланд аудит хийх **4** нийцлийн аудитыг дуусгахаар гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасныг бүрэн хэрэгжүүлээд байна.

Орон нутгийн 2024 төсвийн төсөлд дүгнэлт гаргах аудитын гүйцэтгэлийн үе шатны ажлыг дуусган, тайлагналын үе шатанд ажиллаж байна.

Нийцлийн аудитаар **106.6** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулах **106.6** сая төгрөгийн хугацаатай албан шаардлага, үр ашгийг нэмэгдүүлэх 9 заалт бүхий зөвлөмжийг шалгагдагч байгууллагад хүргүүллээ.

4.1 "Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг хэрэгжүүлж, аудитын тайланг баталгаажууллаа.

Дундговь аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд байгалийн нөөцийг тогтоосон байдлыг авч үзвэл усны болон ан амьтны нөөц тогтоох ажил хийгдэж байсан бол ургамлын нөөц тогтоох ажил ерөнхий судалгааны түвшинд байна.

Усны нөөц тогтоолт: Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Умард гүвээт- Халхын дундад талын сав газрын захиргааны гаргасан 2020 оны мэдээллээр Дундговь аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд газрын доорх усны хайгуул судалгаа хийгдэж, нөөцийг тогтоосон 21 усны нөөц орд байна. Усны нөөц бүхий ордуудаас 2 ордын нөөцийг 2014 болон 2017 онд баталгаажуулсан, 15 ордын нөөцийг 1986-1999 оны хооронд тогтоосон ч ашиглалтын тооцоолол, баталгаажуулалт хийгдээгүй байна. Харин 2009-2013 оны хооронд сумын төвийн бус байршилтай 4 ордын нөөцийг тогтоож, ашиглалтын хугацааг 7-12 жилээр баталсан ч тус ордуудыг ашиглаагүй байна.



Дээрх усны хайгуул хийж нөөц тогтоосон 21 ордоос Сайнцагаан сумын нутагт 6, Луус, Хулд, Өлзийт, Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Дэлгэрцогт, Говь-Угтаал, Өндөршил Сайхан-

Овоо сумдын сумын төвд тус бүр 1 буюу 9 орд, харин Баянжаргалан, Цагаандэлгэр, Гурвансайхан, Өлзийт, Эрдэнэдалай сумын төвийн бус байршилд нийт 6 орд оршиж байна.

Ан амьтны нөөц тогтоолт: Агнуур зохион байгуулалтын судалгааг 5 жил тутамд хийдэг бөгөөд 2023 онд шинээр судалгаа хийхээр төлөвлөөд гүйцэтгэлийн шатанд байна. Ан агнуурын 2017 оны судалгаагаар аймгийн нутаг дэвсгэрт цагаан зээр, хар сүүлт, аргаль хонь, янгир ямаа, тарвага болон бусад хөхтөн амьтдын нөөцийг судалж тогтоосон байна. Судалгааны дүнгээр угалз агнуурын бүс байгуулах боломжтой нутаг Өлзийт, Баянжаргалан, Дэлгэрцогт, Адаацаг сумдад, тэх агнуурын бүс байгуулах боломжтой газар нь Өлзийт, Сайхан-Овоо сум, тарвага агнуурын бүс байгуулах боломжтой газар Баянжаргалан сумын нутагт байхаар үнэлгээ хийгдэж, жил бүр ан агнуурын төрөл дээд хэмжээний саналаа Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлж, батлагдаж ирсэн хяналтын тоогоор орлогын төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлдэг байна.

Их газрын чулууны байгалийн цогцолбор газрын хамгаалалтын захиргаа нь байгуулагдсан цагаас эхлэн хариуцсан нутаг дэвсгэрийн туруутан амьтдын тооллогыг жилдээ 2 удаа зохион байгуулж байгаа бөгөөд 2022 оны тооллогын дүнгээр өмнөх оны тооллого судалгаатай харьцуулан дүгнэхэд аргаль, янгирын тоо төлөөр тогтмол өссөн үр дүнтэй байна. Мөн сүргийн бүтцийн ажиглалт хийхэд аргаль, янгирын 60-70 хувийг эм бодгалийн тоо давамгайлж байгаа нь цаашид уулын туруутан амьтан илүү өсөх хандлагатай байна. Тус нутаг дэвсгэр нь байгалийн цогцолбор газрын ангилалд багтаж, хамгаалалтын захиргаатай болсон тул хуулиар ан агнуурын үйл ажиллагаа явагддаггүй байна.

Ургамлын нөөц тогтоолт: Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас 2018 онд аймгийн нутаг дэвсгэр дээр ургадаг ургамлын ерөнхий судалгааг хийж тодорхойлсон бөгөөд Дундговь аймагт 39 овогт хамаарах 123 төрлийн 202 зүйлийн ургамал хээрийн судалгаагаар бүртгэгдсэн мөн 20 овгийн 28 төрлийн 37 зүйл ургамлын тархац, 9 зүйл ургамлын нөөцийн судалгаа хийгдсэн. Харин нөөцийг тогтоосон нарийвчилсан судалгаа хийгдээгүй тул ургамлын нөөцийг ашиглах талаарх саналыг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлдэггүй байна. 2019 онд судалгааны ажлыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж байгалийн ургамлын менежментийн төлөвлөгөөг батлуулсан байна.

Ойн нөөц тогтоолт: Дундговь аймгийн ойн нөөцийн хувьд Өлзийт сумын нутаг дэвсгэрийн 32,759 га бүхий тусгай хамгаалалттай газрын 16,793 га талбайд Заган ой байна. Тус заган ой нь аймгийн нутаг дэвсгэрийн 0.22 хувийг эзэлж байна. Заган ойг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашигладаггүй байна.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхтэй холбоотой ажлыг хариуцсан байгууллага хоорондын уялдаа холбоо муу, урт хугацааны хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөг төлөвлөхдөө тооцоо судалгаанд үндэслээгүй, жил бүр

хийгдэх ажлын төлөвлөгөөг нарийвчлан гаргаагүй, хэрэгжилтийн үр дүнг тооцоогүй байна.

2. Мал бүхий иргэний хөрөнгийн бүртгэл татварын системд үүсэх боломжгүй шалтгааны улмаас системд ногдуулалт, нэхэмжлэл үүсэх боломжгүй бэлчээрийн татварт ногдуулалт хийхгүй байна.
3. “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам” -д заасан Байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулах төсвийг хууль тогтоомжид заасны дагуу төлөвлөж хуваарилаагүй байна.
4. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн нийт орлогоос хуульд заасан хэмжээгээр байгаль орчныг хамгаалах, нөөцийг нөхөн сэргээх зардлыг батлаагүйгээс 701.0 сая төгрөгийг зарцуулах боломжийг алдсан байна.
5. Дэрэн, Эрдэнэдалай, Өндөршил, Цагаандэлгэр, Сайнцагаан, Адаацаг сумд ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй ажил болох сумын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хогийн цэг шууж булшлахад зэрэг арга хэмжээнд 94.8 сая төгрөгийг ангийн орлогоос зориулалт бусаар зарцуулсан байна.
6. Аймгийн Засаг дарга нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж батлуулаагүй байна.
7. Аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллагаас байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

Аудитаар нийт 106.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 106.6 сая төгрөгийн 2 албан шаардлага, хариуцлага тооцуулах албан шаардлага 1, АИТХ-д-1, Аймгийн Засаг даргад-3, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт-1 нийт 5 зөвлөмжийг хүргүүлж ажиллалаа.

4.2 *Орон нутгийн төсвийн 2024 оны төсвийн төсөлд дүгнэлт гаргах аудит*

Орон нутгийн төсвийн 2024 оны төсвийн төсөлд дүгнэлт гаргах аудитын тайланг тэргүүлэх аудторын тушаалаар баталгаажуулан, аудитын дүнг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 16 дугаар хуралдаанд танилцуулан, хэлэлцүүллээ.

1. *Малын тоо толгойн албан татвар 1,434.0 сая төгрөгийн орлого төвлөрөх боломжтой байна.*

   Малын тоо толгойн албан татварыг 2022 оны жилийн эцсийн мал тооллогын дүн, 2023 оны 10 сарын байдлаарх малын хорогдлын мэдээг үндэслэн сум тус бүрээр тооцоолоход аймгийн дүнгээр 1,434.0 сая төгрөгийн орлого төвлөрөх боломжтой

байна. Иймд сумдын ОНХС-ийн орлогын эх үүсвэр дээрх хэмжээгээр нэмэгдэхээр байна.

2. *Ус ашигласны дүгнэлтийг гаргуулан төлбөрийг хураах ажлыг зохион байгуулах шаардлагатай байна*. Сүүлийн гурван жилийн хугацаанд тус төлбөрийн төлөвлөгөө 389.2-420.7 хувиар буюу 72.3-303.1 сая төгрөгөөр тус тус давж биелсэн. 2021 онд 195.7 сая төгрөг буюу 77.5 хувь, 2022 онд 374.9 сая төгрөг буюу 93.0 хувийг Гурвансайхан суманд уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуй нэгж, байгууллагаас төвлөрүүлж байна. Тус төлбөрийн 2023 оны гүйцэтгэл 593.2 сая төгрөг, хүлээгдэж буй гүйцэтгэл 986.0 сая төгрөг байгаа бөгөөд усны төлбөрийн орлогын гол төвлөрүүлэгч уул уурхайн аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдах тохиолдолд орлогын төлөвлөгөө биелэх боломжтой байна.

3. *Хадгаламжийн хүүгийн орлогыг 2024 онд 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 176.1 сая төгрөгөөр бууруулан 700.0 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна*.

Аймгийн хэмжээнд сүүлийн 22 сарын байдлаар сар бүрийн эцэст байгаа нийт хадгаламжийн үлдэгдэлд үндэслэн шугаман регрессийн шинжилгээгээр прогноз хийхэд 2024 онд дунджаар хадгаламжийн үлдэгдэл 87,632.0 сая төгрөг байхаар тооцоолол гарлаа. 2023 оны эхний 10 сарын байдлаарх хадгаламжийн хүүгийн татварын орлогыг аймгийн хэмжээнд байгаа хадгаламжийн үлдэгдэлтэй харьцуулан, 2024 оны тооцооллоор гарсан хадгаламжийн дундаж үлдэгдэл 87,559.5 сая төгрөгт үндэслэн 2024 оны хадгаламжийн хүүгийн татварын орлогыг тооцоолоход 741.8 сая төгрөг төвлөрүүлэх боломжтой байна.

4. *Аж ахуй нэгж байгууллагаас орох хог хаягдлын хураамжийн ногдуулалт, төвлөрүүлтэд тавих хяналтыг сайжруулах, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, цахилгааны төлбөртэй хамтатган авах хураамжийг тооцоо нийлж баталгаажуулан, хяналт тавьж, орлогыг бүрэн төвлөрүүлэх шаардлагатай байна.*

Сайнцагаан суманд 2021-2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1 цэцэрлэг, 2 сургуулийн барилгыг буулгаж, шинээр барилга барихад барилгын хог хаягдал ихээр гарсан байна. Сайнцагаан сумын 2 дугаар цэцэрлэгээс барилгын хог хаягдлын төлбөр 3.0 сая төгрөг төсөвт төвлөрсөн бол Говийн ирээдүй цогцолбор, Хүмүүнлэг сургуулийн барилгын хог хаягдалд ногдох төлбөрт 31.1 сая төгрөг төвлөрөхөөр байна.

Барилгын болон халаалтын зуухнаас гарах хог хаягдалд хяналт тавьж, батлагдсан хураамжийн дагуу гарсан хог хаягдлын хэмжээгээр төлбөрийн ногдуулалтыг хийж төсөвт хураамжийг бүрэн төвлөрүүлэх шаардлагатай байна.

5. *Сургуулийн дотуур байрны халаалтын талбайг мэргэжлийн байгууллагаар хэмжүүлэн баталгаажуулж, аймгийн хэмжээнд халаалтын зардалтай холбоотой маргаантай асуудлыг нэгдсэн бодлогоор шийдвэрлэх шаардлагатай байна.*

Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн тогтоосон дулааны тариф

Хүснэгт:№4

№	Сум	Сургууль	Эрчим хүчний зохицуулах зөвлөл			Аймаг		Сум	
			Тогтоосон огноо	Дугаар	Хэрэгжиж эхлэх	М2	М3	М2	М3
1	Адаацаг	Алтай авантур ХХК	11/14/2022	15	1/1/2023			800	1450
2	Говь-Угтаал	Ган-Илч ХХК	2/16/2023	152	3/14/2023	880	2252.8	880	2252.8
3	Дэлгэрхангай	Хангай илч ХХК	9/17/2023	6	10/1/2023			990	1925
4	Дэрэн	ОвлСкай ХХК	10/17/2022	13	1/1/2023			800	1450
5	Луус	Тадайма ХХК	9/17/2023	8	10/1/2023			990	1925
6	Өндөршил	Ирмүүнтүшиг ХХК	5/17/2023	9	10/1/2023			990	1925
7	Хулд	Говь Энержи элч ХХК	9/17/2023	5	10/1/2023			990	1925
8	Эрдэнэдалай	Үлэмж Хурд ХХК	1/27/2021	2	1/1/2022			990	1925
9	Сайнцагаан	Дундговь ус ХХК	5/17/2023	11	10/1/2023	800	1750	990	2145

Мөн дулааны тарифыг төсвийн жилийн дундуур нэмж, төлбөртэй холбоотой өглөг, авлагын маргаан үүсэж байна. Энэ нь эрчим хүчний зохицуулах хороо болон зөвлөлийн тогтоолууд нь тухайн жилийн дундуур үнэ тарифад өөрчлөлт оруулан, Төсвийн тухай хуулийн 6.2.5.-д /*төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх*/ заалттай зөрчилдөн төсвийн байгууллага, ААНБ-уудын хооронд гэрээг шинэчлэн хийхэд хүндрэлтэй байдал үүсч тухайн тогтоол хэрэгжих боломжгүй болж байна.

6. *Захиргааны ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Иргэний хуулийн дагуу Төрийн албаны төв байгууллага, Санхүүгийн хяналт, аудитын алба болон тухайн төсвийн байгууллагууд шийдвэрлэгдээгүй 67.1 сая төгрөгийг барагдуулах арга хэмжээ авч, 2024 оны төсвийн зардлын эх үүсвэр болгох нь зүйтэй байна.*

Эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрээр 2016-2022 оны хооронд хууль бусаар ажлаас чөлөөлөгдөж, Шүүхийн шийдвэрээр эргүүлэн томилсон 39 албан хаагчийн ажилгүй байсан хугацааны цалин 155.7 сая төгрөгийг тухайн байгууллагаас нэхэмжлэгчдэд төлсөн байна.

Төрийн байгууллагад учирсан хохирлыг барагдуулах чиглэлээр Төрийн аудитын газар, Прокурорын газар, Санхүүгийн хяналт, аудитын албатай хамтран ажилласнаар 2023 оны 11 дүгээр сарын байдлаар **88.6** сая төгрөгийг барагдуулсан байна. Иймд Захиргааны ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Иргэний хуулийн дагуу Төрийн албаны төв байгууллага, Санхүүгийн хяналт, аудитын алба болон тухайн төсвийн байгууллагууд шийдвэрлэгдээгүй **67.1** сая төгрөгийг барагдуулах арга хэмжээ авч, 2024 оны төсвийн зардлын эх үүсвэр болгох нь зүйтэй байна

7. *Хөрөнгийн хэрэгцээ шаардлага, ашиглалтын урсгал зардлыг тооцох, иргэд олон нийтийн хүртээмж, хөрөнгийн үр ашгийг тооцож цогцоор нь төлөвлөж байх шаардлагатай байна.*

Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хянаж үзэхэд аймгийн урт хугацааны бодлогын баримт бичиг, Засаг даргын мөрийн хөтөлбөртэй нийцүүлсэн ч хэрэгцээ шаардлагыг судлаагүй 251.1 сая төгрөгийн 3 арга хэмжээ, зураг

төсөв, ТЭЗҮ-гүй 429.0 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ буюу нийт 680.1 сая төгрөгийн зөрчилтэй арга хэмжээг төлөвлөсөн байна. Төсвийн тухай хуулийн 29.4 /*хөрөнгө оруулалтын төсөвт техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл арга хэмжээг тусгана*/, Монгол улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 2.2.2 /*төсөл арга хэмжээнийсаналд энэн журамд заасны дагуу судалгаа хийж, эрэмбэлэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нэн тэргүүний ач холбогдолтой төсөл арга хэмжээнүүдийг тодорхойлох, жагсаалт гаргах*/, мөн журмын 2.2.4 /*Төсөл, арга хэмжээний саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байх*/ зэрэг заалтуудыг хэрэгжүүлээгүй, зөрчсөн байна.

Дундговь аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд 17,388.4 сая төгрөгийн хөрөнгө төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлсөн байна. Эдгээр 1,048.3 сая төгрөгийн төсөл арга хэмжээнүүд төлөвлөлтийн шаардлагыг хангахгүй байна. Өмнөх онд 2,010.0 сая төгрөгийн зөрчилтэй арга хэмжээ төлөвлөгдсөн бол 1,728.4 сая болж буурсан ч зөрчил дутагдал бүрэн арилаагүй байна. Цаашид хөрөнгийн хэрэгцээ шаардлага, ашиглалтын урсгал зардлыг тооцох, иргэд олон нийтийн хүртээмж, хөрөнгийн үр ашгийг тооцож цогцоор нь төлөвлөж байх шаардлагатай байна.

"Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх санал дүгнэлт гаргах" нийцлийн аудитын хүрээнд орлого нэмэгдүүлэх 174.7 сая төгрөгийн, орлого олох боломж 1,434.0 сая төгрөг, зардал хэмнэх 195.0 сая төгрөг, зардлын эх үүсвэр бий болгох 67.1 сая төгрөгийн санал хүргүүлж ажиллаа.

Аудитаар 1,728.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж аудитын явцад 25.0 сая төгрөгийн алдаа залруулж, аймгийн Засаг даргад 6, сумдын Засаг дарга нарт 2 зөвлөмж хүргүүлсэн.

4.3 "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт"

Төсвийн шууд захирагч, ОНӨААТҮГ-уудын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитын гүйцэтгэлийн үе шатанд шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавих ажлыг зохион байгуулаа. 2023 онд нийт 154,180.8 сая төгрөгийн 9100 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулахаас 16,624.1 сая төгрөгийн 1603 мэдээллийг мэдээлээгүй, 3,107.4 сая төгрөгийн 428 мэдээллийг хугацаа хоцроосон 39 байгууллагад зөрчлийг таслан зогсоох хугацаатай албан шаардлага, 1 байгууллагад хариуцлага тооцох албан шаардлага, 36 байгууллагад зөрчил арилгах зөвлөмж өгч ажилласан байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавих ажлыг зохион байгуулж, ФАС системд үр дүнг оруулсан. ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 10.2 тэр бум төгрөгийн 36 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

4.4 “Орон нутгийн хурлын нөхөн сонгуульд оролцох бие даагч, нам, эвслийн мөрийн хөтөлбөр, хандивын тайланд дүгнэлт гаргах”

Орон нутгийн хурлын нөхөн сонгуульд оролцох Адаацаг, Баянжаргалан, Өлзийт, Хулд сумын Монгол ардын, Ардчилсан намын мөрийн хөтөлбөр, хандивын тайланг төрийн аудитын байгууллагад ирүүлсэн. Бие даан нэр дэвшигчдийн хувьд 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт хандивын тайланг ирүүлэх ёстой ч нөхөн сонгуульд бие даан нэр дэвшигч нэр дэвшээгүй байна.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн тухай дүгнэлт гаргав.

Мөн 2023 оны нөхөн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацаанд хандив хүлээн аваагүй, хандивын орлого бүртгэгдэж тайлагнаагүй тул дүгнэлт гаргаагүй.

4.5 Орон нутгийн хурлын нөхөн сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, гүйцэтгэлд аудит хийх

Орон нутгийн хурлын 2023 оны нөхөн сонгууль зохион байгуулсан Адаацаг, Баянжаргалан, Өлзийт, Хулд сумд болон аймгийн Сонгуулийн хорооны нөхөн сонгууль зохион байгуулсан зардлын гүйцэтгэлд хяналт хийж, зардлын тайланг баталгаажуулаа. Нөхөн сонгуулийг зохион байгуулахад Адаацаг сум 12,777.0 мянга, Баянжаргалан сум 11,452.0 мянга, Өлзийт сум 10,337.0 мянга, Хулд сум 11,312.0 мянга, аймгийн сонгуулийн хороо 20,155.0 мянган төгрөг нийт 66,033.0 мянган төгрөг зарцуулсан байна.

4.6 Орон нутгийн 2023 оны нөхөн болон дахин сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх

Нөхөн сонгууль зохион байгуулагдсанаас хойш 30 хоногийн дотор нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан төрийн аудитын байгууллагад ирүүлэх ёстой бөгөөд нэр дэвшигч нар сонгуультай холбоотой тусгайлан данс нээгээгүй гэсэн тайлбарыг өгч, тайланг ирүүлээгүй. Иймд зардлын тайлангаа хуульд заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй нам эвсэл, нэр дэвшигчдэд Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.22[1] –т заасан үндэслэлээр Зөрчлийн тухай хуулийн 17.1.25[2]-д заасны дагуу арга хэмжээ авч хариу мэдэгдэх талаар аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст 2023.09.27-ний өдрийн 1/114 тоот албан бичиг хүргүүлээд байна.

---

[1] /нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 9.4 дүгээр зүйлийн 1, 5 дахь хэсэг, 9.8 дугаар зүйл, 9.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 11.1 дүгээр зүйл, 11.10 дугаар зүйлийн 14 дэх хэсэг, 11.13 дугаар зүйл, 11.18, 11.20, 11.25, 11.27 дугаар зүйл, 17.1 дүгээр зүйлийн 25, 27 дахь хэсэгт заасан зөрчил;/

[2] Нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно./

5

БУСАД АУДИТ, АРГА ХЭМЖЭЭ, ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

5. БУСАД АУДИТ, АРГА ХЭМЖЭЭ, ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

5.1 Үүрэг даалгаврын биелэлт

5.1.1 Үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх 26 зорилтоос 26 зорилт арга хэмжээг хэрэгжүүлж, үндсэн чиг үүргийн хэрэгжилт 100 хувь байна. Нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх 12 зорилтоос 12 зорилтыг хэрэгжүүлж, нийтлэг чиг үүргийн хэрэгжилт 100 хувь байна. Үйл ажиллагааны чанар, хүртээмжийг сайжруулах 10 зорилтыг төлөвлөсөн хүрэх түвшинд 100 хувь хэрэгжүүлсэн байна. Ингэснээр 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг **100** хувьд хүргэсэн байна.

5.1.2 2023 онд гаргасан аймагт хамааралтай 21, 2022 оноос үргэлжлэн хэрэгжиж буй 4, нийт 25 “А” тушаалын хэрэгжилтийг тайлагналаа.

5.1.3 Төрийн аудитын газрын 14 хоногийн товч тайланг 13 удаа Захиргаа, хууль эрх зүйн газарт хүргүүлж, үйл ажиллагааг 14 хоногоор төлөвлөн, тайлагнасан. Ингэснээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэх, удаашралтай байгаа арга хэмжээг эрчимжүүлэх ажлыг тухай бүр зохион байгуулсан.

5.1.4 Удирдах ажилтны зөвлөгөөнөөс 7 үүрэг даалгавар өгсөн. 2023 онд 6 үүрэг даалгаврын хэрэгжилтийг бүрэн тайлагнасан.

5.1.5 Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/104 дүгээр тушаалаар батлагдсан “Аудитын сэдэв сонгох ажиллагааны журам”-ын дагуу орон нутгийн иргэдийн амьдралд эерэг нөлөө үзүүлэх, олон нийтийн анхааралд байгаа үнэн зөв хариу хүссэн нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудалд судалгаа хийж, аудитын сэдвийн матриц хөтөлж, 2024 онд гүйцэтгэх аудитын сэдвийг иргэдээс Googleform ашиглан санал авсан. Аудитын сэдвийн матрицаар үнэлж, сэдвийн судалгаанд үндэслэн "***Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголттой холбоотой хууль, журмын хэрэгжилт***"-д нийцлийн аудит, "***Орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, үр дүн***"-д гүйцэтгэлийн аудит хийхээр санал хүргүүллээ.

6 ДОТООД АЖИЛ

(مكتوب فى مجلة ورشة عمل)

6. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

6.1 ХҮНИЙ НӨӨЦ

Төрийн аудитын газар нь 2023 онд ажилтнуудын багаар ажиллах, дүн шинжилгээ хийх чадварыг нэмэгдүүлэх тал дээр анхаарал хандуулан ажиллахаар төлөвлөөд байна.

Тэргүүлэх аудитор “ТАБ-ын Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх журам"-ын дагуу 10 ажилтны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэхэд хяналт тавьж ажиллаж байна.

2023 оны 4 улирлын гүйцэтгэлийн тайланг үнэлгээний хуудсаар үнэлж, ажилтнуудад танилцуулав. Ажилтнуудын гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээнд үндэслэн, 5 албан хаагчийн зэрэг дэвийн нэмэгдлийг ахиулан олгох хүсэлт, 1 ажилтныг “Хөдөлмөрийн хүндэт” медальд тодорхойлон МУЕА-т санал хүргүүллээ.

Мөн Монгол Улсад санхүүгийн алба үүсэж хөгжсөний 112 жилийн ой, “Бүртгэл, санхүү, эдийн засгийн ажилтны өдөр”-ийн баярын хурлын үеэр Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох "Нягтлан бодох бүртгэлийн тэргүүний ажилтан" цол тэмдэг, аудитын менежер Х.Наранцацрал Сангийн яамны “Жуух бичиг”, ахлах аудитор Д.Ихбаяр, аудитор Д.Должинсүрэн нар “Аймгийн хүндэт тэмдэг”-ээр тус тус шагнууллаа.

6.2 МЭРГЭЖЛИЙН ТАСРАЛТГҮЙ СУРГАЛТ

6.2.1 Байгууллагын дотоод сургалт

Төрийн аудитын байгууллагын 2023 оны зорилт, Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр ажилтнуудын сургалтын хэрэгцээнд тулгуурлан “**Сургалт, хөгжлийн төлөвлөгөө**”-г баталж хэрэгжүүллээ.

Байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөнд ажилтнуудын ур чадварыг сайжруулах, аудитын ажлыг сайжруулахад чиглэсэн сургалтын сэдвүүдийг хамруулан боловсруулсан.

Байгууллагын дотоод сургалтын жилийн төлөвлөгөөнд нийт 11 сургалт зохион байгуулахаар төлөвлөж, бүх сургалтыг 2023 оны 03-11 сарын хооронд хуваарийн дагуу зохион байгуулж ажиллаа.

Үүнд:

1. ***2023 онд гүйцэтгэх санхүүгийн аудитад баримтлах чиглэл арга зүй”***

“Төрийн аудитын байгууллагаас 2022-2023 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”–ийн хүрээнд санхүүгийн тайлангийн аудитын явцад учирч болох эрсдэл, түүнийг шийдвэрлэх арга замыг данс бүрээр тодорхойлж, байгууллагуудад гарч болох нийтлэг эрсдэлийн цахим санг салбар байгууллагаар гарган, хэлэлцүүлэг зохион байгуулан, санхүүгийн тайлангийн аудит хийх явцад ашигласан.

2. “Санхүүгийн тайлангийн аудитад анхаарах асуудлууд”

2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг шинэчлэгдсэн Fas.audit.mn системээр гүйцэтгэх болсон тул сургалтын явцад шалгагдагч байгууллагын аудитын төлөвлөлтийн үе шатыг шинэчлэгдсэн системээр гүйцэтгэх, мөн системийн шинэчлэлээс гадна шинээр томилогдсон албан хаагчдад аудитын стандарт, арга зүйн талаар ойлголт өгсөн.

3. “Аудитын чанарын хяналтын журам”

Аудитын үе шатны чанарын хяналтын хуудсыг ахлах аудитор, аудитын менежер, тэргүүлэх аудитор тус бүр хөтлөх тул тухайн ажилтнууд ямар нотлох баримтад үндэслэн хяналтыг хийх, тайлбарыг хяналтын хуудсанд оруулах, нотлох баримтын загвар маягтыг бэлтгэх чадвар эзэмшсэн. Ингэснээр чанарын хяналтыг хэрэгжүүлэх ажилтан ямар нотлох баримтад үндэслэн үнэлгээг хийх талаар тодорхой ойлголт олж авсан.

4. "Аудитын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний үр дүн"

Аудитын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний үр дүнг хэрхэн дээшлүүлэх, цаашид ямар арга замаар өмнөх 2 жилд гүйцэтгэсэн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актын хэрэгжилтийг чанартай хангуулах талаар арга зүйн сургалт, зөвлөгөөг өгч, санал, асуулт хариулттайгаар зохион байгуулсан нь “Аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод байдлыг сайжруулах” жилийн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой сургалт боллоо.

5."Төрийн сангийн удирдлагын цахим систем"

Тус сургалтыг нийт албан хаагч нарт өгсөнөөр төрийн сангийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа программын онцлог давуу, өмнөх прораммаас шинэчлэлт хэрхэн хийгдсэн, бусад төрийн байгууллагын мэдээллийн системүүдтэй уялдаж, холбогдож байгаа талаар тодорхой мэдлэг олгож сонирхсон асуултад хариултыг өгсөн байна.

6. "Алсын хараа-2050 Монгол Улсын хөгжлийн бодлого"

Тус сургалтаар тодорхой ойлголт мэдлэг өгөх, мэдлэгийг бататгах зорилгоор сургалтын материалыг цахим хэлбэрээр бэлтгэн таралаж, судлуулсан бөгөөд албан хаагчдын мэдлэгийг шалгах, ойлголтыг нэгтгэх асуулт хариултыг зохион байгуулаа.

7. "Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга"

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу "Хөдөлмөрийн тухай хууль"-ийн шинэчилсэн найруулга сэдвээр Дундговь аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга Б.Мөнхчулууныг урин, сургалт зохион байгуулж, сонирхсон асуултууддаа хариултыг авсан байна.

8."Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга"

Сургалтаар Монгол Улсын хөгжлийн бодлогыг боловсруулах, батлах, төлөвлөх, хэрэгжүүлэх, түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааны талаар албан хаагч нарт ойлголт мэдлэг олгосон сургалтыг зохион байгуулсан байна.

9. "Байгууллагын соёл, түүний ойлголт"

Байгууллагын соёл, түүнийг хэрхэн байгууллагад төлөвшүүлэх, байгууллагын соёл гэж юу вэ? талаар сургалтыг зохион байгууллаа. Сургалтад Төрийн аудитын байгууллагын нийт албан хаагчдыг хамруулаад байна.

10. "Эксел программ дээр ажил хөнгөвчлөх үйл, томьёо"

Энэхүү сургалтын онцлог нь аудит хийхдээ ашигладаг эксэлийн үйлдэл функцүүдийг тодорхой жишээн дээр бүх суралцагчид зэрэг загвар файл дээр ажиллан, харилцан ярилцаж, ажилласнаараа илүү үр дүнтэй болсон. Сургалтаар эксэлийн 10 үйл, 2 функцийг ашиглан ажил, мэдээ, судалгааг хялбарчилж, хөнгөвчилөн, цаг хэмнэх боломжийг олгосон үр дүнтэй байлаа.

11. Инфографикийг хэрхэн бэлтгэх арга зүй

Байгууллагын албан хаагчдыг Adobe illustrator программ дээр ажиллуулж, Tool-үүд дээр хэрхэн ажиллах, гараас tool дуудах үсэг, дүрслэл зурах, инфографик бэлтгэх дадлага ажлууд хийлгэж арг зүйгээр хангасан тус сургалт нь аудиторуудын хувьд гүйцэтгэсэн аудитын тайлангийн инфографикийг чанартай гүйцэтгэдэг болох чадварт ахиц өгөх сургалт болсон байна.

Тухайн жилд зохион байгуулсан сургалтууд нь ажил хөнгөвчлөх, сургалтын үр дүнд заасан агуулгыг бодит байдалд хэрэгжүүлэх боломжтой, шинэ тутам батлагдсан хууль, эрх зүйн мэдлэгийг олж авч албан ажилд ашиглахад практик ач холбогдол бүхий сургалтууд болсон байна. Газрын даргаар батлагдсан төлөвлөгөөт сургалтуудыг зохион байгуулахад төсөв хөрөнгө шаардагдаагүй байна.

Ажилтнуудын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор ажлын байранд нь сургах сургалтыг тогтмолжуулж, мэдлэг мэргэжлийг нь дээшлүүлэх, хөгжүүлэх, мэргэшүүлэх сургалтад хамрагдахад нь байгууллагын зүгээс зохих дэмжлэг үзүүлж, нөхцөл бололцоог хангаж ажиллав. Ингэснээр ахлах аудитор Д.Ихбаяр, аудитор Ж.Угтахбаяр, Л.Уранбилэг нар ММНБИ-ээс зохион байгуулдаг эрх сунгах сургалтад, Тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох "Аудиторын сургалт"-нд, 5 ажилтан "Мэргэшсэн нягтлан бодогчийн тасралтгүй боловсролын сургалт"-д тус тус хамрагдаж, өөрийн мэдлэг чадварыг дээшлүүллээ.

6.2.2 Үндэсний аудитын газраас зохион байгуулсан сургалт



ҮАГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газраас зохион байгуулсан 7 цахим сургалтад Төрийн аудитын газрын бүх ажилтнууд хамрагдлаа.

Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэй "Төрийн аудитын байгууллагын чадавхыг бэхжүүлэх" төслийн гурав дахь бүтээгдэхүүн болох "Монгол Улсын Үндэсний аудитын газрын сургалт, хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах" дэд төслийн хүрээнд боловсруулагдсан баримт бичгүүд, түүнийг хэрэгжүүлэх зөвлөмжүүдийг танилцуулах хэлэлцүүлэгт 1 ахлах аудитор, аудитын менежер, дарга, тэргүүлэх аудитор, нийт 3 хүн оролцсон. "Ур дүнд суурилсан төсвийн төлөвлөлт" сургалтад аудитын менежер, нягтлан бодогч аудитор нар оролцсон. Удирдах ажилтны сургалт, семинарт дарга тэргүүлэх аудитор, аудитын менежер нар оролцсон. Аудитын шийдвэрийн хэрэгжилт, үр нөлөөг тооцох бодлого, арга зүйн өнөөгийн байдлыг дүгнэх, тулгамдсан асуудлууд, тэдгээрийг боловсронгуй болгох саналуудыг нэгтгэн томьёолох зорилгоор "Аудитын шийдвэрийн хэрэгжилт, үр нөлөөг тооцох бодлого, арга зүй" сэдэвт хэлэлцүүлэгт 2023.05.26-ны өдөр тэргүүлэх аудитор, менежер нар оролцсон.

6.3 ИРГЭД ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦАА

6.3.1 "Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах стратеги"-ын хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, дарга, тэргүүлэх аудитораар батлуулсан. Төлөвлөгөөнд 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай байна.

Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажсан аудитын тайлангуудыг audit.mn, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын facebook хуудсанд тус тус байршуулж, аудитын дүн, анхаарах асуудлыг аймгийн "Дундговийн амьдрал" сонинд нийтлүүлж

хэвшээд байна. 2023 онд 2 мэдээллийг сонинд нийтлүүлж, 2 мэдээлэл хэвлүүлэхээр хүлээгдэж байна.

Байгууллагын цахим хуудсанд 2023 онд төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 30 мэдээллийг байршуулж, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар facebook хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэсэн байна. Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой "Үндэсний аудитын газар" facebook хуудас болон audit.mn цахим хуудсанд байршуулсан мэдээллийг орон нутагт түгээх ажлыг байгууллагын facebook хуудсаар дамжуулан зохион байгуулж байна.

Байгууллагын цахим хуудсанд хандах хандалтын тоог нэмэгдүүлэх, орчин үеийн мэдээлэл хүргэх чиг хандлагыг судлан, мэдээллийг хурдан бөгөөд ойлгомжтой байдлаар олон нийтэд хүргэх зорилгоор инфографик бэлтгэж, байгууллагын мэдээллийн самбар болон facebook хуудсанд байршуулав.

6.3.2 Санхүүгийн тайлангийн аудитын 140 хураангуй тайлан, нийцлийн аудитын 8 тайлан, гүйцэтгэлийн аудитын 4 тайланг "Open.audit.mn" цахим сайтад байршуулан олон нийтэд мэдээлсэн. Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл түгээх чиглэлээр зохион байгуулсан ажлын үр дүнд Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны болон гүйцэтгэсэн аудитын талаар олон нийт мэдээлэлтэй болж, байгууллагын Facebook хуудасны хандалтын тоо 2023 оны 12 сарын байдлаар 50228-д хүрсэн байна.

6.5 ХАРИЛЦАГЧ ТАЛУУДТАЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦАА

“Төрийн аудитын байгууллагын 2019-2023 онд хэрэгжүүлэх харилцагч талуудын оролцооны стратеги”-ийг 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, дарга, тэргүүлэх аудитораар батлуулсан. Төлөвлөгөөнд 7 төрлийн харилцагч талуудтай харилцах харилцааг сайжруулах зорилтын хүрээнд 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. 2023 оны 12 сарын байдлаар байдлаар 15 арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнаж, төлөвлөгөөний хэрэгжилт **100** хувьтай байна.

Тайлант онд харилцагч талуудын үр ашигтай хамтын ажиллагааг дэмжих, аудитын чанар, нийгэмд үзүүлэх үр өгөөжийг дээшлүүлэх чиглэлээр дараах ажлыг зохион байгуулаа. Үүнд:

6.5.1 2023 онд гүйцэтгэсэн "Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын явцад Дундговь аймгийн ЗДТГ, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Эко үйлчилгээ ТББ-ын хамтарсан "Дундговь аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгаа", "Дундговь аймгийн байгалийн ургамлын менежментийн төлөвлөгөө", Умард говийн гүвээт- Халхын дундад талын сав газрын захиргааны гаргасан " 2020 оны мэдээллээр Дундговь аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд газрын доорх усны хайгуул судалгаа", Эрүүл мэндийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголын хөдөлмөрийн эрүүл ахуйчдын үндэсний холбооноос хамтарч хийсэн "Хөдөө орон нутгийн хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн чанар аюулгүй байдлын судалгаа" зэрэг судалгааны тайлан мэдээллийг ашигласан. Хог хаягдлын менежментийг сайжруулах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар статистикийн мэдээллийн сайт, говийн бүсийн аймгуудын хот тохижуулах газрын хог хаягдалтай холбоотой судалгаа, тоон мэдээллүүдийг авч дүн шинжилгээ хийж үр дүнг аудитын тайланд тусгасан. Сүхбаатар аймгийн хог хаягдлыг ангилах, дахин боловсруулахтай холбоотой хэрэгжүүлсэн арга хэмжээг сайн жишээ болгон аудитын тайланд тусгасан.





Аудитын сэдвийн хүрээнд холбогдох мэргэжлийн байгууллагын хийсэн судалгааны тайлан, үр дүнтэй танилцаж, аудитад ашиглаж хэвшиж байна.

6.5.2 Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяаны байгууллагуудын нягтлан бодогч, сумдын санхүүгийн албаны дарга нарт 2022 оны төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын дүн, аудитаар илэрсэн нийтлэг зөрчил, түүний шалтгаан, цаашид анхаарах асуудлаар сургалт зохион байгууллаа.

6.5.3 Дундговь аймгийн ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан, дүгнэлтийг ИТХ-ын ээлжит 14 дүгээр хуралдаанд танилцууллаа.

6.5.4 Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан "Удирдлагын манлайлал-2023" зөвлөгөөнд Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох оролцлоо. Тус зөвлөгөөнд сумдын болон хэлтэс, агентлагийн удирдлагуудаас бүрдсэн 200 хүн оролцсон бөгөөд Дундговь аймгийн хөгжлийг тодорхойлоход манлайлал, уялдаа, хамтын ажиллагааг бэхжүүлж, нэгдсэн мэдээллээр хангах зорилготой юм. Зөвлөгөөний үеэр Төрийн аудитын газраас "Төсөв захирагч нарын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитын дүн", " 2023 оны санхүүгийн тайлангийн аудитад анхаарах асуудал", "Төрийн аудитын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт" сэдвүүдээр мэдээлэл хийж, оролцогчдын асуусан асуултад хариулт өглөө. Мөн зөвлөгөөнд оролцсон удирдлагуудын дунд Төрийн аудитын байгууллагын талаар асуулт асууж мэдлэгийг сориход 80 хувь нь асуултад амжилттай хариулсан сайн үзүүлэлттэй байгаа нь Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал хангагдаж байгааг илтгэж байна.

6.6 ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам, Төрийн аудитын байгууллагын төрийн болон албаны нууц хамгаалах дотоод журмын хэрэгжилтийг хангах хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт хийх жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулав.

Төрийн болон албаны нууцыг хамгаалах төлөвлөгөөний дагуу бүх ажилтнуудын нууцын баталгааг шинэчилж баримтжуулан, нууцын албан хэрэг хөтлөлтийн 10 дэвтрийг хөтөлж, ажилтнуудын нууцын баталгааг шинэчлэн баримтжуулсан.

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас 2022 онд хэрэгжүүлсэн төрийн болон албаны нууц хадгалах, хамгаалах ажлын тайланг ҮАГ, Дундговь аймаг дахь Тагнуулын хэлтэст хүргүүллээ.

6.7 АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төрийн аудитын газрын авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны дэд төлөвлөгөөг боловсруулан, дарга, тэргүүлэх аудиторaар батлуулаа.

Төлөвлөгөөний дагуу 5 зорилтын 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 16 арга хэмжээг төлөвлөсөн хэмжээнд гүйцэтгэснээр төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь байна.



Аудит бүрд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх маягтыг баримтжуулан ажиллаж, санхүүгийн тайлангийн аудитын үеэр ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал үүссэн 5 тайлбар, мэдэгдлийг цахим хуудсанд бүртгэлээ.

Авлигатай тэмцэх газраас санаачлан зохион байгуулж буй "Авлигын Эсрэг Нэгдье" аянд нэгдэж байгууллагын facebook цахим хуудсанд зурагт хуудас, видео шторкуудыг байршуулж, олон нийтэд түгээж байна.



Авлигатай тэмцэх газрын даргын 2019 оны А/40 дугаар тушаалаар батлагдсан "Авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлал"-ын дагуу Төрийн аудитын газрын ажилтнуудаас санал асуулгыг авч, нэгтгэн дүгнэсэн. Санал асуулгад байгууллагын чиг үүрэг, бүтэцтэй холбоотой 5, хүний нөөцийн удирдлагатай холбоотой 5, үйл ажиллагаа, шийдвэр гаргах үйл явцтай холбоотой 2, ил тод байдалтай холбоотой 2, ёс зүй болон шударга ёстой тогтолцооны 3, хариуцлагын механизмтай холбоотой 1, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэлтэй холбоотой 3, нийт 21 асуултыг багтаасан. Санал асуулгын дүнгээс үзэхэд Төрийн аудитын байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх эрмэлзэл 83 хувь, байгууллагын ил тод байдал 100 хувь, ёс зүйн болон шударга ёсны тогтолцоо 85 хувь гэсэн үр дүн гарч байна.



"Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, дүгнэсэн. Санал асуулгад нийт 41 шалгагдагч байгууллага хамрагдсан бөгөөд нийт оролцогчдын 67.5 хувь нь төрийн аудитын байгууллагын хяналт шалгалтад 4 ба түүнээс дээш удаа хамрагдсан байна. “Төрийн аудитын байгууллагын ажилтны зүгээс бэлэг, шан харамж, аудит гүйцэтгэсний төлөөх ажлын хөлс шаардах тохиолдол байсан уу?” гэсэн асуултад санал асуулгад оролцогчид бүгд “огт тийм зүйл гардаггүй” гэсэн хариултыг өгсөн нь авлигын эрсдэл бага байгааг илтгэж байна. Мөн аудитор, шинжээчид мэргэжлийн ёс зүйг хэр баримталж ажилласан гэж үзэж байгааг тодруулахад 80 хувь нь ёс зүйтэй гэж хариулжээ. Санал асуулгын дүнд төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой саналыг авч нэгтгэн, ажилтнуудад танилцуулсан. Шалгагдагч байгууллагатай хамтран ажиллах асуудлыг үнэлэхэд 87.5 хувь нь хангалттай гэж хариулсан байна.

6.8 АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ

Төрийн аудитын газар нь байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хууль тогтоомж, зааварт нийцүүлэн ажиллаж байна.

1. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны хүрээнд:



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2023 оны 03 сарын 21 өдөр Дугаар А/04 Мандалговь

Баримт нягтлан шалгах комиссын
бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалаар батлагдсан "Аймаг найслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх үүрэг"-ийн 2.4, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын нягтлан шалгах комиссын дараах бүрэлдэхүүнтэй өөрчлөн байгуулсугай. Үүнд:

Дарга:	Д.Должинсүрэн
Нарийн бичгийн дарга	Л.Уранбилэг
Гишүүд:	Б.Гаптуяа
	Ж.Уттахбаяр
	Ж.Мөнхбал

2. Байгууллагын нягтлан шалгах комиссын дүрэм, байгууллагын архивын ажлын үндсэн заавар, журмын дагуу ажил үүргээ гүйцэтгэхийг баримт нягтлан шалгах комиссын дарга /Д.Должинсүрэн/-д үүрэг болгосугай.
3. Байгууллагын баримт бичиг нягтлан шалгах комиссын дүрмийг хавсралтаар баталсугай.
4. Энэ тушаал гарсантай холбогдуулсан Тэргүүлэх аудиторын 2022.10.19-ны өдрийн А/28 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

Р.МӨНХТОГТОХ

Тэргүүлэх аудиторын 2023 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн А/04 тоот тушаалаар БНШК-ын бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг 2023 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн БНШК-ын хурлаар шинэчлэн баталса.

(ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР)

НЭГ. АРХИВЫН ГЭРЧИЛГЭЭ

1. Архив байгуулагдсан огноо : 2003 он
2. Архивын хаяг : Нутгийн удирдлагын ордон, С.Буяннэмэхийн өргөн чөлөө 2-205, 7-р баг, Сайнцагаан сум, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 213 тоот

/зип код, оршин буй газрын нэр, гудамж талбайн нэр,дугаар/

3. Харилцах утас, факсын дугаар 70593202
4. Архивын цахим хуудас,емайл:dundgovi@audit.gov.mn
5. Гэрчилгээ олгосон байгууллагын нэр Дундговь аймаг дахь Төрийн архив
6. Гэрчилгээ олгосон:
7. огноо: 2023 оны 10 дугаар сарын 01

Монгол Улсын хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/222 тоот тушаалаар Дундговь аймгийн төрийн архивын тасагт хүсэлт гаргаж байгууллагын архивын гэрчилгээг баталгаажууллаа.

Төрийн аудитын газарт 2023 оны 12 сарын байдлаар нийт 379 албан бичиг ирж, харилцагч байгууллагад 368 албан бичгийг хүргүүлэн, 25 тушаалыг баталгаажуулав.

Аудитаар шалгагдагч байгууллагуудад тогтоосон 102 төлбөрийн акт, зөрчил арилгах 258 албан шаардлагыг хэвлэж, дугаарлаж хүргүүлсэн. Санхүүгийн тайлангийн аудитын үеэр 145 аудитын дүгнэлт буюу гэрчилгээг хэвлэсэн байна.

Аудиторуудын боловсруулсан төлбөрийн акт, албан шаардлага, зохион байгуулалт, мэдээлэл лавлагааны баримт бичгийн боловсруулалтад аудитын менежер, тэргүүлэх аудитор нар үе шатны хяналт тавьж, архивд баримт бичиг хүлээлгэн өгөхөд архив хариуцсан ажилтан баримт бичгийн бүрдүүлэлт, архив, бичиг хэргийн стандартын хэрэгжилтийг хянан авч, заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.

2. Байгууллагын архивын үйл ажиллагааны хүрээнд:

Архивын хууль тогтоомжийн дагуу баримт хадгаламжийн нэгжийг ажилтнуудаас хүлээн авч, архивлах ажлыг хэрэгжүүлдэг. Нийт ажилтнуудыг "Монгол Улсын баримт, бичгийн стандарт MNS 5140-1-3:2021" сэдэвт сургалтад хамруулсан.

2023 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулан Баримт нягтлан шалгах комиссын хурлаар хэлэлцэн, тэргүүлэх аудитораар баталгаажуулав.

Аймгийн төрийн архивын мэргэжилтнээс заавар, зөвлөгөө авч архивын 2012-2022 оны баримтыг эмхлэн цэгцэлж, хадгаламжийн нэгж бүрдүүлсэн байдалд хяналт хийн, архивын баримтын бүрдэл дутуу /баталгааны хуудас, товьёг, дугаарлалт, нүүр/ 169 ботийг цэгцлэн стандартын дагуу болгож, баримт бүрдлийг хангуулсан. 2023 оны 12 сарын байдлаар хөтлөгдөж буй албан хэргийг "ХХИ"-ийн дагуу ангилан төрөлжүүлж 2022 оны санхүүгийн аудитын нийт 143 хадгаламжийн нэгж хүлээн авч хамгаалалтын хайрцагт хийж хаягжуулан архивлаж, баримтыг цаасан суурьтайгаар ажилчдаас хүлээн авсан.

Байгууллагын архивд хадгалагдаж байгаа баримт бичгүүдэд үзлэг хийн гэмтэлтэй баримтыг илрүүлэн аймгийн архивын ахлах мэргэжилтний зөвлөмжийн дагуу сэлбэн засварлаж сэргээн шинэчилж 2012-2022 оны нийт 971 боть баримтыг хайрцаглаж аймгийн архивд хүлээлгэн өгөхөд бэлэн болгосон.

Мөн архивын өрөөнд засвар хийж, архивын тоног төхөөрөмжийг сайжруулж, аймгийн Засаг даргын Тамгын газарт хүсэлт өгсний дагуу 3 ширхэг архивын баримт хадгалах нягтруулсан шүүгээг шийдвэрлүүлэн архивын өрөөг тохижуулаад байна.

3. Өргөдөл, гомдол, түүний шийдвэрлэлт

Төрийн аудитын газарт 2023 онд 1 өргөдөл бүртгэгдсэнээс өргөдлийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн. Өргөдөл гомдол ирүүлсэн иргэн, өргөдлийн агуулга, өргөдөл ирүүлсэн хугацаа, хариу хүргүүлсэн хугацаа, хариу хүргүүлсэн хэлбэр зэрэг мэдээллийг агуулсан бүртгэлийг хөтөлж, өргөдөл, гомдлын бүртгэл, тайланг баримтжуулан ABLE системд бүртгэсэн.

7 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

7. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

7.1 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

7.1.1 2022 оны санхүүгийн тайланг УСНББОУС-д нийцүүлэн гаргаж “Мишээл Од” аудитын компанид 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр буюу Төсвийн тухай хуульд заасан хугацаанд хүргүүлсэн. “Мишээл Од” аудитын компани аудитыг гүйцэтгэж, 40.1 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 3.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж хүргүүлэн, “Өөрчлөлтгүй санал дүгнэлт” гаргасан байна. /Хавсралт №1/

7.1.2 2023 онд 572.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 11 дүгээр сарын 30-ний өдрийн байдлаар 516.5 сая төгрөгийн санхүүжилт авч эдийн засгийн ангиллын дагуу 483.9 сая төгрөгийг зарцуулан 32.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Албан хэрэгцээнд 9.3 сая төгрөгийн тавилга, эд хогшил, 6.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авсан байна.

Үзүүлэлт	Төлөвлөгөө /жилээр/	Гүйцэтгэл /11 сарын байдлаар/	Үлдэгдэл
Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	473.7	401.6	72.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60.6	50.7	9.9
Хангамж, бараа материалын зардал	7.9	6.1	1.9
Эд хогшил, урсгал засварын зардал	16.5	16.2	0.3
Томилолт, зочны зардал	6.8	6.8	0.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5.5	2.4	3.1
Бараа үйлчилгээний бусад зардал	0.4	0.0	0.4
Урсгал шилжүүлэг	0.8	0.2	0.5
	572.2	483.9	88.3

Нэмэлт санхүүжилтийн дансанд шалгагдагч 17 байгууллагын 12.2 сая төгрөгийн орлогыг 100 хувь төвлөрүүлж үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого дансанд бүртгэсэн. Мөн “Си Пи Ти Эй Аудит” ХХК, “Азуре Хүлүг-Аудит” ХХК-иудтай гэрээ байгуулан шалгагдагч 58 байгууллагын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгэж 35.3 сая төгрөгийн аудитын төлбөрийг төсөвт байгууллагаас нэмэлт санхүүжилтийн дансанд татан төвлөрүүлж, харилцагч ХАК-д төлбөрийг 100 хувь барагдуулсан.

7.1.3 2023 онд 572.2 сая төгрөгийн төсөв батлагдсан нь өмнөх оноос 99.3 сая төгрөөр өссөн байна. Энэ нь үйл ажиллагааны урсгал зардлуудыг бууруулж баталсан ч төрийн албан хаагч нарын цалинг 2023 оны 07 дугаар сарын 01 ээс нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал өссөнтэй холбоотой байна.

Үзүүлэлт	Батлагдсан төсөв		Өөрчлөлт
	2022 он	2023 он	
1	2	3	4=3-2
Цалин, нэмэгдэл хөлс	375.9	473.7	97.8
Нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47.4	60.6	13.2
Хангамж, бараа материалын зардал	10.2	7.9	-2.3
Эд хогшил, урсгал засварын зардал	24.6	16.5	-8.1
Томилолт, зочны зардал	5.4	6.8	1.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	7.8	5.5	-2.3
Бараа үйлчилгээний бусад зардал	0.8	0.4	-0.4
Урсгал шилжүүлэг	0.8	0.7	0.0
	472.9	572.2	99.3

Харин 2024 оны төсвийн төслийг тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж, ҮАГ-ын Захиргаа, хууль эрх зүйн газарт хүргүүлсэн. Төсвийн төсөлд урсгал зардлыг өмнөх оноос нэмэгдүүлэн 578.0 сая төгрөг байхаар санал хүргүүлсэн нь тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж 52.0 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 27.5 сая төгрөгийг тус тус төлөвлөсөнтэй холбоотой байна.

7.2 ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Төрийн аудитын газар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2023 оны 11 дүгээр сарын байдлаар батлагдсан төсвийг цаг хугацаанд нь цахимаар болон самбараар мэдээлсэн. Сар бүр, тухай бүр мэдээлэх мэдээлэл, 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтын гүйлгээ гараагүй, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын 522.0 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн мэдээлсэн. Өмч хөрөнгө, өр авлага үүсгэсэн, мөнгө зарцуулсан аливаа шийдвэр гаргаагүй гэж мэдээлсэн.

7.3 ХӨРӨНГИЙН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ

7.3.1 Байгууллагын хөрөнгийн тооллогыг хийж, эд хөрөнгийн бүртгэлийг санхүүгийн программын бүртгэл болон албан хаагч бүрийн ашиглалтын карт, бүртгэлтэй тулган, нэр төрөл ангиллын дагуу болгон цэгцэлж, тулгасан.

Эд хөрөнгийн тооллогоор 57 нэр төрлийн 147.6 сая төгрөгийн эргэлтийн бус хөрөнгө, 68 нэр төрлийн 14.9 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгө тоологдож, хагарч, эвдэрсэн, ашиглах боломжгүй болсон 10 нэр төрлийн 1.3 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийг Тэргүүлэх аудиторын тушаалаар актлуулахаар, 11 нэр төрлийн 11.8 сая төгрөгийн эргэлтийн бус хөрөнгийг акталж данснаас хасах саналыг Өмч хамгаалах зөвлөлд оруулахаар бэлтгэж, баримтыг хүлээлгэн өглөө.

7.3.2 Өмч хамгаалах зөвлөлийн 2023 оны төлөвлөгөөг 2023.04.05-ны өдөр дарга, тэргүүлэх аудиторааар батлуулан, 11 арга хэмжээг 2, 3, 4 дүгээр улиралд хэрэгжүүлэхээр төлөвлөж, 12 дугаар сарын байдлаар байдлаар төлөвлөсөн 11 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын жолоочтой бүрэн хариуцлагын гэрээг байгуулж, баталгаажуулсан. Тооллогын комиссоос ирүүлсэн актлах хөрөнгийг нүд үзэн шалгаж, актлах дүгнэлтийг бэлтгэлээ. Албан хэрэгцээнд худалдан авсан 9.3 сая төгрөгийн тавилга, эд хогшил, 6.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг бүртгэлжүүлэн, хадгалалт хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна.

8 ДҮГНЭЛТ, САНАЛ

Байгууллагын 2023 оны үйл ажиллагаагаа төрийн аудитын байгууллагын стратеги, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 онд дэвшүүлсэн “**"Аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах"** зорилтод чиглүүлэн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, үр дүнг тооцон ажиллаа.

Зорилтыг хэрэгжүүлэх дэд төлөвлөгөөний дагуу өмнөх онуудад гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудитын тайлагналын дараах үе шатны ажлыг хэрэгжүүлж, уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, үр дүнг нэгтгэн тайлагналаа. Цаашид жил бүр өмнөх онд гүйцэтгэсэн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг давтан хянах нь аудитын үр дүнг илүү бодитой тооцох боломжтой болохоор байна.

“Төрийн аудитын байгууллагаас 2022-2023 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл” –ийн хүрээнд чиглэлийг аймгийн онцлогт тохируулан боловсруулж, тэргүүлэх аудитораар батлуулав. Санхүүгийн тайлангийн аудитын явцад учирч болох эрсдэл, түүнийг шийдвэрлэх арга замыг данс бүрээр тодорхойлж, байгууллагуудад гарч болох нийтлэг эрсдэлийн цахим санг салбар байгууллагаар гарган аудитдаа ашигласан.

Гүйцэтгэлийн аудитын сэдвийн хүрээнд мэргэжлийн байгууллагаас хийсэн судалгааны тайланг үндэслэн дүгнэлт гаргасан нь гүйцэтгэлийн аудитын чанарыг ахиулсан ажил болов.

2023 онд ажилтнуудын хувийн хөгжил болон багаар ажиллах, дүн шинжилгээ хийх ур чадварыг нэмэгдүүлэх тал дээр анхаарал хандуулан аудитын чанарыг сайжруулахаар зорьсон. Энэ ажлын хүрээнд ажилтнуудын хэрэгцээ шаардлагад тулгуурлан Сургалт, хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүллээ.

Мөн төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд түгээх ажлыг тал бүрээр санаачлан хэрэгжүүлж ажилласны үр дүнд байгууллагын цахим хуудасны хандалтын тоо 50228-д хүрсэн байна.

Хавсралт №1

БАЙГУУЛЛАГЫН 2022 ОНЫ АУДИТЫН ДҮГНЭЛТ

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК

Нягтлан бодох бүртгэл- Аудит, Баталгаажуулалт, Аутсорсингийн үйлчилгээ, Бизнесийн зөвлөгөө өгөх

__2023.03.24___ № ___23/ҮАГ-10___

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА Р.МӨНХТОГТОХ ТАНАА

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.2, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар дахь Төрийн аудитын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын батлсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд нэмэлт төсвийн дансанд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 11,076.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тайлант онд 2 хөтөлбөрийн 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, 89.8 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

МОА-2023/ҮАГ-10/СТА-ТШ3 3

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ОДОНЧИМЭГ

УЛААНБААТАР ХОТ
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК
9020010058
5201203 СБТ111121

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2 хороо, 2 хороолол Энхтайвны өргөн чөлөө Эрхи центер 703 тоот
Веб хуудас: www.misheelodaudit.mn , И-мэйл: info@misheelodaudit.mn Утас: +976 70169029; 99069029; 99065204;

Монгол Улс, Дундговь аймаг 48090, Сайнцагаан сум, Нарлаг баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39
E-mail: dundgovi@audit.gov.mn